ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ДАВААГИЙН ЦЭНДСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт (хувь) |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.“ОЛОН УЛСЫН ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ, ТҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| | Арга хэмжээ 1.1 Гаалийн хяналтад эрсдэл тооцох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.1 Гаалийн хяналтад эрсдэл тооцож дүн шинжилгээ, судалгаа хийж, үр дүнг тооцох | Хэрэгжилт: Тайлант хугацаанд системийн хэмжээнд эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, эрсдэлт орчныг тодорхойлох, судалгаанд суурилсан шийдвэр гаргах, гаалийн байгууллагын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах макро түвшний 10, микро түвшний 42 судалгааг хийж гүйцэтгэсэн<br>• Гадаад худалдааны орчны судалгаа 2023;<br>• БТКУС-ийн 8703 кодод хамаарах суудлын автомашины бүрдүүлэлт;<br>• Гаалийн хяналтын төлөвийн хэрэгжилт;<br>• Эрсдэлийн шалгуурын судалгаа;<br>• Гаалийн мэдүүлгийн шалгалтын үр дүнгийн судалгаа;<br>• Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчдийн судалгаа;<br>• ЗҮГГ-т аж ахуйн нэгж, иргэдийн “итгэмжлэл олгон, төлөөлөгчөөр дамжуулан” хийсэн гаалийн бүрдүүлэлтийн дүн шинжилгээ.<br>• Гаалийн байгууллагын эрсдэлийн судалгаа<br>• Эрсдэлийн удирдлагын программын “Сонгон шалгах шалгуур”-ын ногоон төлөвийн бүрдүүлэлтийн эрсдэлийн судалгаа<br>• Монгол Улсын Гаалийн байгууллага дахь тоон гарын үсгийн хэрэглээний өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ<br>Хүрсэн түвшин:<br>Үүний үр дүнд Татварын ерөнхий газартай улсын төсвийн орлогоос зайлсхийх эрсдэлийг бууруулах, бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулах аж ахуйн нэгж, иргэнийг сонгох, шалгалтын үр дүнгийн саналаар худалдаа эрхлэгчдийн хууль сахилтыг дээшлүүлсэн.<br>• Гадаад худалдааны орчны судалгааны үр дүнд хамгийн их бүрдүүлэлт хийсэн иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалтыг гарган, Татварын ерөнхий газарт хүргүүлэн, хамтарсан эрсдэл тооцож, хууль сахилт өндөр болон бага худалдаа эрхлэгчээр 5 эрсдэлийн профайлыг, 7 хяналтын хуудас, 156 эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хамт боловсруулж, Эрсдэлийн удирдлагын программд оруулж, эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг сайжруулсан;<br>• Япон Улсаас БТКУС-ийн 8703 зүйлийн түвшинд суудлын машин импортлох иргэдийн судалгааны үр дүнд эрсдэлийн шалгуур үзүүлэлт боловсруулж, Эрсдэлийн удирдлагын программд оруулж гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацааг бууруулсан;<br>• Гаалийн хяналтын төлөв сонгогдсон байдалд дүн шинжилгээ хийж, эрсдэлийн шалгуур тус бүрийн хэрэглээг гарган, эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын стратегийн судалгаанд суурилсан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлсэн;<br>• Бичиг баримтын болон бараанд хийх шалгалтын үр дүнгийн санал тогтмол хугацаанд, стандартын дагуу дүн шинжилгээ хийж, гаалийн хяналтын үр нөлөөг сайжруулж, ГУБ нарын ажлын хариуцлагыг нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд ГУБ нар шалгалтын үр дүнгийн санал буруу бичих эрсдэл буурсан;<br>• Улсын төсвийн орлогоос зайлсхийх эрсдэлт орчныг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор ЗҮГГ-т аж ахуйн нэгж, иргэдийн гаалийн бүрдүүлэлт хийх үйл ажиллагааг итгэмжлэл олгон, төлөөлөгчөөр дамжуулан хийж буй гаалийн бүрдүүлэлтэд | 2024.01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүн шинжилгээ хийж, 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр 2024/32 дугаар дотоод зурвасаар бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулахаар БДШГ-т хүргүүлсэн. | | |
| | | | | 1.2 Эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийж, эрсдэлийн удирдлагын программд оруулах | Хэрэгжилт:<br>- КАИС-ийн Эрсдэлийн удирдлагын программын мэдээллийн санд 2024 оны байдлаар 8 профайл, 186 хяналтын хуудсаар 683 шалгуур үзүүлэлтийг үзүүлэлтийг боловсруулж, эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан. (Хавсралт 2-оор жагсаалт оруулав)<br>· Эрсдэлийн удирдлагын “Заавал шалгах шалгуур”-т 188,<br>· “Зөвшөөрөгдсөн шалгуур”-т 268,<br>· “Өндөр эрсдэлийн шалгуур”-т 132,<br>· “Үл хамаарах шалгуур”-т 78,<br>· “Заавал шалгах шалгуураас хасах”-13,<br>· “Зөвшөөрөгдсөн шалгуураас хасах”-7,<br>· “Үл хамаарах шалгуураас хасах”-10,<br>· “Санамсаргүй болон Өндөр эрсдэлийн шалгуурын хувь хэмжээ өөрчлөх”-2 нийт 698 шалгуур боловсруулсан байна.<br>- Эрсдэлийн шалгуурын 38.4 хувь “Зөвшөөрөгдсөн шалгуур”, 26.9 хувь “Заавал шалгах шалгуур”, 18.9 хувь “Өндөр эрсдэлийн шалгуур” үлдсэн хувийг бусад шалгуур эзэлсэн.<br>- Эрсдэлийн судалгаа, дүн шинжилгээний үр дүнгээр бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдах ААНБ жагсаалтыг БДШГ-т хүргүүлж хамтран ажилласан. 2024 оны эхний 11 сарын байдлаар Бүрдүүлэлтийн дараах шалгалтад тус хэлтсээс 302 ААН шалгах хүсэлт хүргүүлснээс нийт 58 аж ахуйн нэгж (ААН) хамрагдсан.<br>- БДШ-ын үр дүнгээр боловсруулсан эрсдэлийн шалгуурын тоо:<br>- БДШГ-аас 2024 онд 3 дотоод зурвас (81/24, 115/24, 185/24)-аар нийт 54 ААН-ийн эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт ирүүлсэн. Үүнээс 6 ААН нь 2023 оны эрсдэлийн шалгуурын программд хэрэгжиж байгаа тул 20 хяналтын хуудсаар, 48 эрсдэлийн шалгуурыг боловсруулсан. Үүнд:<br>· Заавал шалгах шалгуурт 12 хяналтын хуудсаар 40 ААН;<br>· Өндөр эрсдэлийн шалгуурт 4 хяналтын хуудсаар 4 ААН;<br>· Үл хамаарах шхалгуурт 2 хяналтын хуудсаар 2 ААН;<br>· Зөвшөөрөгдсөн шалгуурт 2 хяналтын хуудсаар 2 ААН-ийг эрсдэлийн шалгуурын программд оруулсан.<br>- Тус хэлтэс Эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг сайжруулах чиглэлээр өмнөх жилүүдэд ГЕГ-ын дарга холбогдох нэгжид хүсэлт тавьсаны үр дүнд БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (КОЙКА)-ийн буцалтгүй тусламжаар “Монгол улсын Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын мэдээллийн системийг боловсронгуй болгох, шинэчлэх, чадавхыг бэхжүүлэх төсөл” хэрэгжихээр болсон. Үүнтэй уялдан ГЕГ-ын даргын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/624 дүгээр тушаал, төсөв, уулзалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулсан. БНСУ-ын КОИКА байгууллагын техник эдийн засгийн судалгаа хийх багтай хэд хэдэн цахим уулзалт хийж, хамтран ажилласан. СЯ, ГЕГ-ын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын газар, хэлтсийн удирдлага, холбогдох албан хаагч, УБГГ, гаалийн зуучлагч, тээвэрлэгчдийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, ЧХОУНБГГ, УБГГ, Туушин терминал, ШХТ-ийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцуулсан. Мөн тайлангийн хурал зохион байгуулж ажилласан.<br>Хүрсэн түвшин:<br>- Эрсдэлийн удирдлагын программд 2024 онд оруулсан шалгуур үзүүлэлтийн тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 105 шалгуураар илүү буюу 15.04 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>- Дээрх эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийснээр 2024 онд нийт 1,109,566 гаалийн бүрдүүлэлт хийгдсэнээс нийт дүнгээр улбар шар төлөвт 47%, улаан төлөвт 37%, ногоон төлөвт 16% сонгогдсон. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Импортын бүрдүүлэлт: Улаан төлөвт 82% нь сонгогдсон нүүр тулсан харилцаа хэт өндөр, хяналт шалгалт энэ хирээр удаан явагдаж байна.<br>Импортын бүрдүүлэлтэд гаалийн хяналтын улаан төлөв өндөр байгаа нь “Заавал шалгах шалгуур” профайлд хорио цээрийн хяналт, гаалийн лабораторийн шинжилгээнд хамрагдах бараа (БТКУС-ийн код)-ны эрсдэлийн шалгуур үзүүлэлт 85 орчим хувийг эзэлж байна. Иймд ГТЛ, ХЦХ-тэй байнга уялдаа холбоотой ажиллаж, хууль сахилт өндөр ААН, иргэний мэдээллийг солилцон ажилласан.<br>- Мөн “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”-ийг ГЕГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/287 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-ын 3.8 дахь хэсгийн 3.8.5 дахь хэсэгт “эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг гаалийн улсын байцаагч боловсруулж, хяналтын хуудас бүхий маягтыг бөглөж, баталгаажуулан тухайн эрсдэлийн профайлд хавсаргах” гэдэгт нэмэлт, өөрчлөлт оруулж, МЗХ-аар батлуулав.<br>Экспортын бүрдүүлэлт: Улбар шар төлөв 65%, ногоон төлөвт 23% сонгогдсон өмнөх оноос 4%-өөр өссөн. Энэ нь экспортыг дэмжих бодлого барьж байгаа харагдаж байна.<br>- Стратегийн түвшний өндөр эрсдэл бүхий экспорт, импортын бүрдүүлэлттэй холбоотой шалгуур үзүүлэлтийг тухай бүр боловсруулан, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийж, эрсдэлийн удирдлагын программд холбогдох анхааруулгын хамт оруулан, эрсдэлийг бууруулан ажилласан болно.<br>- Бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдсан ААН-ын шалгалтын үр дүнд төсөвт 2.47 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,18 тэрбум төгрөг нь төлөгдөж, 1,28 тэрбум төгрөгийн акт төлөгдөөгүй байна. Үүнээс:<br>- Зөрчил илэрсэн: 40 ААН<br>- Зөрчил илрээгүй: 12 ААН<br>- Хойшлогдсон: 1 ААН<br>- Дуусаагүй шалгалттай: 3 ААН<br>- Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн: 2 ААН<br>- БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (КОЙКА)-ийн буцалтгүй тусламжаар “Монгол улсын Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын мэдээллийн системийг боловсронгуй болгох, шинэчлэх, чадавхыг бэхжүүлэх төсөл” 2025-2028 онд хэрэгжихээр болсон. | | |
| | | | | 1.3. Эрсдэлийн мэдээллийн сангийн баяжилтыг нэмэгдүүлэх (Зорчигч, ААН, бараа, тээврийн хэрэгсэл зэрэг | Хэрэгжилт:<br>- Эрсдэлийн мэдээллийн сангийн баяжилтыг ААН, бараагаар нэмэгдүүлэх үүднээс эрсдэлийн шалгуур боловсруулж, эрсдэлийн удирдлагын программд оруулсан. Үүнд: ЗББНДБ-аас ирүүлсэн санал, тус хэлтсээс хийсэн судалгааны үр дүнд үндэслэн тайлант хугацаанд 460 ААН, БТКУС-ийн ангиллын код буюу барааны 305 шалгуур эрсдэлийн мэдээллийн санд давхардсан байдлаар оруулж, баяжилт хийсэн.<br>- CAIS системийн RM цэсний “Зорчигч онилох Модуль”-д агаарын зорчигчийг APIS программаар, авто зам болон галт тэрэгний зорчигчийг “Эрсдэлтэй зорчигчийн сан”-д тулгуурлан эрсдэлтэй зорчигчийг танихад ашиглан ажиллаж байна. Мөн “Бэлэн мөнгөний хяналт” программд тулгуурлан эрсдэлтэй зорчигчийг таньж тогтоож байна.<br>- Зорчигч: APIS программд 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар давхардсан нийт тоогоор 1,569,107 агаарын хилээр нэвтэрсэн зорчигчийг бүртгэсэн байна. Эрсдэл бүхий зорчигчийн 3867 бичлэг бүртгэсэн ба үүнээс 3043 зорчигчийг хилийн хөдөлгөөнд хяналт тавьж, шалгалтад хамруулан үр дүнг “Шалгалтын үр дүн” программд оруулсан байна.<br>- Онилсон зорчигчийн шалгалтын үр дүнгийн саналаас харахад бусад 68.3%, зөрчилгүй 28.9%, 0.23% нь захиргааны зөрчил илэрсэн, 0.8% гаалийн бүрдүүлэлтийн хуудас бичсэн, 0.9% саатуулсан, 0.8 эрсдэлтэй байж болзошгүй гэсэн тайлбар тус тус эзэлжээ.<br>- Эрсдэлийн удирдлагын программын “Зорчигч онилох модуль”-ийн “Эрсдэлтэй зорчигчийн мэдээллийн сан”-г шалгалтын үр дүнгийн санал болон бусад эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн эрсдэлтэй байх магадлалтай 134 зорчигчийн мэдээллээр баяжуулсан.<br>- Эдгээрийн 94% Монгол Улсын, БНСУ-ын иргэн 2.24%, БНХАУ-ын иргэн 1.49%, Энэтхэг, Турк, Ветнам улсын иргэд тус бүр 0.75% байна. Бүртгэсэн мэдээллийг гаалийн газар, хороодоор авч үзвэл Чингис Хаан Олон Улсын нисэх буудал дахь гаалийн газар 85.1%, Замын -Үүд дэх гаалийн газар 13.4%, Гаалийн ерөнхий газар 1.49%-ийг тус тус эзэлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - “Зорчигч онилох модуль”-ийн “Бэлэн мөнгөний хяналт” талбарт зорчигчийн бэлэн мөнгөний мэдээллийн жагсаалтыг 26 улсын 2,993 зорчигчийн “Овог, Нэр, Харьяалал, Хүйс, Төрсөн огноо, Паспортын дугаар, Регистр №, Валютын код, Валютын хэмжээ, Мөнгөний зориулалт, Мөнгөний эх сурвалж, Газар, хороо, Чиглэл, Аяллын зорилго, Аяллын дугаар, Мэдүүлсэн огноо, Аяллын маршрут” гэсэн 17 үзүүлэлтээр нийт 175,670 өгөгдлөөр баяжуулсан байна.<br>- Зорчигчийн бэлэн мөнгө мэдүүлсэн байдалд дүн шинжилгээ хийхэд 2024 оны 11 сарын байдлаар 19 валютаар мэдүүлсэн байна. Эдгээрээс хамгийн их буюу 82.6 хувийг ОХУ-ын рубль, 7.43 хувийг АНУ-ын ам. доллар, 4.2 хувийг БНХАУ-ын юань, үлдсэн 5.8 хувийг бусад 16 улсын валют эзэлжээ.<br>- Улсын хилийн орох чиглэл 73.3 хувь, гарах чиглэл 26.3 хувийг, 0.4 хувийг дамжин өнгөрөх чиглэл эзэлснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бараг ижил байна. Аяллын зорилгоор дүн шинжилгээ хийхэд бусад 43 хувь, аялал 35 хувь, албан 14 хувь, үлдсэн 7 хувийг зочлох, суралцах, бизнес эзэлсэн ба өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Жуулчлал, зочлох 20.7 хувиар буурч, бусад18.5 хувиар өссөн байна.<br>- Тайлант хугацаанд хялбаршуулах журмаар шийдвэрлэсэн зөрчил 2942 байна. Үүнээс иргэний зөрчил 3.4% буюу 99 байна. Зорчигчийн зөрчлийг хялбаршуулах журмаар шийдвэрлэсэн байдлыг харьяа гаалийн газар, хороодоор үзүүлбэл Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар 39.4%, Улаанбаатар хот дахь гаалийн газар 23.2%, Чингис Хаан Олон Улсын нисэх буудал дахь гаалийн газар 15.2%, Замын Үүд дэх гаалийн газар 12.1%, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар 5.0%, Ховд аймгийн Булган дахь гаалийн газар 3.0%, Дорнод дахь гаалийн газар 2.0% эзэлсэн байна.<br>- Системийн хэмжээнд зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журмын дагуу авч үзэхэд Татвар хураамжийн орлогын хуудас (Маягт № 1)-аар 4,642 бүрдүүлэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.54 дахин өссөн. Зорчигчийн барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудас (Маягт №2)-аар 10,613 бүрдүүлэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.65 дахин өссөн байна. Тайлант хугацаанд зорчигчийн арилжааны шинжтэй бараанд Маягт №2-оор хийсэн гаалийн бүрдүүлэлтийн тоо хэмжээ 2.65 дахин өссөн нь ногдуулж, хураасан гаалийн болон бусад татварын дүнг 2 дахин нэмэгдүүлэхэд нөлөөлжээ.<br>Хүрсэн түвшин:<br>- Эрсдэлийн мэдээллийн санд шалгуур оруулж, баяжилт хийсэн байдал нь өнгөрсөн оны мөн үеэс 15.04%-ын шалгуураар өссөн байна.<br>- 2024 оны 11 дүгээр сарын байдлаар эрсдэл бүхий зорчигчийн 3867 бичлэг бүртгэсэн ба үүнээс 3043 зорчигчийг хилийн хөдөлгөөнд хяналт тавьж, шалгалтад хамруулан үр дүнг “Шалгалтын үр дүн” программд оруулсан байна.<br>- Зорчигчийн эрсдэлийн мэдээллийн сангийн ШҮД-ийн саналаас харахад Шалгалт хийсэн үндэслэлийн шалгалтын үр дүнг үзвэл: Захиргааны зөрчил илэрч зөрчлийн тэмдэглэл хөтөлсөн 7, Зорчигчийн гаалийн бүрдүүлэлтийн хуудас бичсэн 23, Саатуулсан 28 шалгалтын үр дүнтэй байна. Үүнд:<br>○ 42 зорчигчийн арилжааны шинж чанартай бараанд ЗБГБХ Маягт-2 бичиж, 5.94 сая.төгрөгийн татвар ногдуулж барагдуулсан;<br>○ 37 мэдүүлгээр нийт 102.5 сая.төгрөгийн татварыг ногдуулж, барагдуулсан;<br>○ 3.1 сая.төгрөгийн торгуулийг төлүүлсэн байна.<br>- Агаарын тээврээр зорчсон эрсдэлтэй зорчигчийн санд шинээр 134 зорчигчийн мэдээллийг оруулсан. Мэдээллийн эх сурвалжаар төрөлжүүлэн авч үзэхэд Гаалийн байгууллага 76%, Цагдаагийн байгууллага үлдсэн 21%, үлдсэн 3%-ийг бусад байгууллага эзэлжээ.<br>- “Зорчигч онилох модуль”-ийн “Бэлэн мөнгөний хяналт” талбарт зорчигчийн бэлэн мөнгөний мэдээллийн жагсаалтыг 26 улсын 2,993 зорчигчийн 17 үзүүлэлтээр нийт 175,670 өгөгдлөөр баяжуулсан.<br>- Хялбаршуулах журмаар шийдвэрлэсэн 2942 зөрчил бүртгэгдсэн. Үүнээс иргэний зөрчил 3.4% буюу 99 байна. “Эрсдэлтэй зорчигчийн сан”-д үндэслэн онилогдсон зорчигчийг таних, ажиглалт хийх, шалгах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулан зөрчлийг илрүүлэн, нийт 37,218,252.67 төгрөгийг торгууль ногдуулсан байна.<br>- Зөрчлийн тухай хуулийн 11.21 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт зөрчсөн 92, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчсөн 1, Эм, эмнэлэгийн хэрэгслийн тухай хууль зөрчсөн 6 иргэн байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Зорчигчийн арилжааны шинжтэй барааны бүрдүүлэлт (Маягт № 1; 2)-д ногдуулж, хураасан гаалийн болон бусад татварын дүн 2 дахин нэмэгдсэн байна. | | |
| | | | | 1.4 Бараанд хийх бичиг баримтын болон биет шалгалтаас чөлөөлөгдөх хувь хэмжээг нэмэгдүүлж, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангана. | Хэрэгжилт: Бараанд хийх шалгалтаас чөлөөлөгдөх хувь хэмжээ:<br>2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн гаалийн бүрдүүлэлт:<br>- Экспортын гаалийн бүрдүүлэлт: Бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 88% болж, өмнөх оны мөн үеэс 4%-иар өссөн байна. Мөн экспортын улаан төлөвийг 4%-иар бууруулжээ.<br>- Импортын гаалийн бүрдүүлэлт: Бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 18% байна.<br>- Нийт гаалийн бүрдүүлэлт: Бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 63% байна.<br>Хяналтын төлөв 2023 2024 2023 2024 2023 2024<br>Импорт Экспорт Нийт гаалийн бүрдүүлэлт<br>Ногоон 6% 3% 43% 23% 30% 16%<br>Улбар шар 18% 15% 41% 65% 34% 47%<br>Улаан 75% 82% 16% 12% 36% 37%<br>Гаалийн системийн хэмжээнд нийт 1,109,566 гаалийн бүрдүүлэлт хийгдсэнээс импортын 400,834, экспортын 708,732 бүрдүүлэлт хийгдсэн байна. Хяналтын төлөвт сонгогдсон байдал:<br>Нийт гаалийн бүрдүүлэлт:<br>- Ногоон төлөв: 176,990 бүрдүүлэлт буюу 16%;<br>- Улбар шар төлөв: 523,330 бүрдүүлэлт буюу 47%;<br>- Улаан төлөв: 409,545 бүрдүүлэлт буюу 37%;<br>Импортын гаалийн бүрдүүлэлт:<br>- Ногоон төлөв: 12,306 бүрдүүлэлт буюу 3%;<br>- Улбар шар төлөв: 60,523 бүрдүүлэлт буюу 15%;<br>- Улаан төлөв: 328,005 бүрдүүлэлт буюу 82%;<br>Экспортын гаалийн бүрдүүлэлт:<br>- Ногоон төлөв: 164,384 бүрдүүлэлт буюу 23%;<br>- Улбар шар төлөв: 462,808 бүрдүүлэлт буюу 65%;<br>- Улаан төлөв: 81,540 бүрдүүлэлт буюу 12%.<br>Төлөв өөрчлөлтийн үр дүнг өмнөх онтой харьцуулахад: Ногоон төлөвт 45%, улбар шар төлөвт 79%-иар бууруулсан байна.<br>Төлөв өөрчлөлт 2023 2024 Хувь<br>Төлөв өөрчлөлт 45 25 55.56%<br>Засварт буцаалт 3736 2723 72.89%<br>Баталгаажсаны дараа 1320 949 71.89%<br>Баталгаажихын өмнө 2416 1774 73.43%<br>- Эрсдэлийн судалгаа, дүн шинжилгээний үр дүнгээр бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдах ААНБ жагсаалтыг БДШГ-т хүргүүлж, ААНБ-ын хууль сахилтыг тодорхойлоход хамтран ажилласан.<br>- 2024 оны эхний 11 сарын байдлаар Бүрдүүлэлтийн дараах шалгалтад тус хэлтсээс 302 ААН шалгах хүсэлт хүргүүлснээс нийт 58 аж ахуйн нэгж (ААН) хамрагдсан. Шалгалтын үр дүнд төсөвт 2.47 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,18 тэрбум төгрөг нь төлөгдөж, 1,28 тэрбум төгрөгийн акт төлөгдөөгүй байна.<br>Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр:<br>- БНХАУ, БНСУ-тай байгуулсан Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Уг хэлэлцээрт экспортыг дэмжих, гаалийн хяналтад зарцуулах хугацаа бууруулах чиглэлээр ажиллах юм.<br>- "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулах орны тоог нэмэгдүүлэх, экспортод зарцуулах хугацаа бууруулах ажлын хүрээнд ОХУ-ын ХГА-ны Гаалийн хяналт бүрдүүлэлтийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулах төв газар, Гадаад хамтын ажиллагааны нэгжтэй 2024 оны 03 дугаар сарын 10-ны өдөр цахим уулзалт зохион байгуулсан.<br>- ГИААН хөтөлбөрийг сурталчилан таниулж, Гаалийн итгэмжлэлийг гадаад худалдаанд оролцогч ААН-д итгэмжлэл олгох ажлыг зохион байгуулж, холбогдох программ хангамжийг хөгжүүлж байна. Тус хөтөлбөрт Говь ХК, АПУ ХК, Сор кашимер ХХК, Ханбогд кашимер ХХК, Янмал ХХК хамрагдах хүсэлт гаргасан ба тус хэлтсээс холбогдох шалгуурын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. | | |
| | | | | 1.5 Аж ахуйн нэгж өөрийн хууль сахилтыг өөрөө үнэлдэг, гаалийн байгууллагатай хууль сахилтыг дэмжих чиглэлээр хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн байна. | Хэрэгжилт:<br>- Хууль сахилтын программын хөгжүүлэлтийг хийх бодлогын даалгавар МТГ-т 2024 оны 04 дугаар сарын 09-ний өдрийн 2024/065 дотоод зурвасаар хүргүүлсэн. АХБ-ны санхүүжилтээр хийгдэж буй Интерактив төслийн баг буюу хорио цээрийн программ хангамжид тус бодлогын даалгавраар эрсдэлийн удирдлагын дэд модульд оруулсан. CAIS-тай холбогдоход бэлэн болсон.<br>- “Risk management 2023-2024” групп нээж, харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлага хариуцсан албаны дарга, ГУАБ, ГУБ нарыг аж ахуйн нэгж өөрийн хууль сахилтыг өөрөө үнэлдэг, гаалийн байгууллагатай хууль сахилтыг дэмжих, хамтран ажиллах чиглэлээр шуурхай мэдээллээр хангаж ажиллав.<br>- Гаалийн байгууллага ААН-ийн хууль сахилтыг дэмжих бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны үр дүнгээр харьяа гаалийн газар, хороодыг мэдээллээр хангаж ажиллав. Гаалийн байгууллагын “Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа 2023”-ны үр дүнгээр харьяа гаалийн газар, хороодын гаалийн улсын байцаагч нарын чадавхийг бэхжүүлэх сургалтыг ГЕГ-т 2024 оны 11 дүгээр сарын 5-6-нд зохион байгуулсан. Энэхүү сургалт нь гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг илүү шуурхай, оновчтой болгох зорилготой бөгөөд оролцогчдод “Time Release Study” буюу барааг гаалийн хяналтад авснаас эхлэн хилийн чанадад гаргах хүртэлх хугацааг хэмжих аргачлалыг зааж сургасан. Сургалт танхим болон цахимаар нийт 50 гаруй гаалийн улсын байцаагч хамрагдсан.<br>- Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн Зүйл 7.5 Бүрдүүлэлтийн дараах шалгалт арга хэмжээний хэрэгжилтийг хангах, аж ахуйн нэгжийг өөрийн хууль сахилтыг хангахад чиглэсэн арга хэмжээний хэрэгжилтйг хүргүүлж, ажиллав.<br>- Дэлхийн гаалийн байгууллагын “Меркатор” хөтөлбөр болон Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чадавхыг бэхжүүлэх онош зүйн шинжилгээний тайланг Гаалийн ерөнхий газрын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Эрсдэлийн удирдлагын хэлтсээс бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулах 303 аж ахуйн нэгж, иргэний мэдээллийг хүргүүлж, харилцан мэдээлэл солилцон хамтарсан эрсдэл тооцон ажиллах үйл ажиллагааг хэвшүүлсэн.<br>- Аж ахуйн нэгж өөрийн хууль сахилтыг өөрөө үнэлдэг, гаалийн байгууллагатай хууль сахилтыг дэмжих чиглэлээр БНХАУ, БНСУ-тай байгуулсан Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>- ГИААН хөтөлбөрийг сурталчилан таниулж, Гаалийн итгэмжлэлийг гадаад худалдаанд оролцогч ААН-д итгэмжлэл олгох ажлыг зохион байгуулж, холбогдох программ хангамжийг хөгжүүлж байна. Тус хөтөлбөрт Говь ХК, АПУ ХК, Сор кашимер ХХК, Ханбогд кашимер ХХК, Янмал ХХК хамрагдах хүсэлт гаргасан.<br>- Их түмэн санаачилгын Гаалийн дэд хорооны болон Худалдаа хөрөнгө оруулалтын 6 дугаар хуралдаан 2024 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан.<br>Хүрсэн түвшин:<br>- АХБ-ны санхүүжилтээр хийгдэж буй Интерактив төслийн баг буюу хорио цээрийн программ хангамжид тус бодлогын даалгавраар эрсдэлийн удирдлагын дэд модульд оруулсан.<br>- ГЕГ-ын ЭУХ, харьяа гаалийн газар, хороодын чиглэл хариуцсан албан хаагчид судалгаа, дүн шинжилгээ хийх, гаалийн хяналтын төлөвт дүн шинжилгээ хийх, аж ахуйн нэгж, иргэдийн хууль сахилтыг тодорхойлох болон худалдааг хөнгөвчлөх чиглэлээр оны эхнээс 63 зураг, хүснэгт, ворд файл солилцож ажилласан.<br>Сургалтаар олгосон мэдээлэл, үр дүн:<br>- Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг сайжруулах: | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Оролцогчид гаалийн үйл ажиллагааны үе шат бүрд зарцуулж буй хугацааг хэмжих, үйл ажиллагааны үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлсон;<br>- Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилт: Гаалийн бүрдүүлэлтэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, саад тотгорын тухай ойлголтой болсон;<br>- Техникийн чадварыг бэхжүүлэх: Оролцогчид эксэл программ ашиглан өгөгдөл боловсруулах, алдаа засварлах, цаг хугацааны дараалалд мэдээллийг оруулах, бүрдүүлэлтийн горимыг шалгах зэрэг практик чадваруудыг эзэмшсэн.<br>- Оролцогчид мөн ITDM төслийн баг-ийн дэмжлэгтэйгээр дэлхийн “Global trend TRS” болон МУИС, ГЕГ-ийн илтгэлтэй танилцсан.<br>- Мөн Tableau, хиймэл оюун ухаан ашиглан бүрдүүлэлтийн цаг хугацааг хэмжих аргачлал, CAIS программтай мэдээллээ хэрхэн нягтлан шалгах зэрэгтэй танилцсан.<br>- Эрсдэлийн удирдлагад суурилсан бүрдүүлэлтийн дараах шалгалтыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, 303 аж ахуйн нэгжийн хууль сахилтыг тодорхойлж, холбогдох эрсдэлийн тодорхойлолт үүсгэн, худалдааг хөнгөвчлөхөд дэмжлэг үзүүлсэн. ГХЯ-нд хэрэгжилтийг хүргүүлсэн.<br>- ХХЗХ-ийг хэрэгжүүлэх ажлыг хүрээнд БНСУ, БНХАУ-ын гаалийн байгууллагаас тус бүр 3 ГИААН-ийн мэдээллийг хүлээн авч, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын мэдээллийг цахимаар илгээж, мэдээлэл солилцсон. Хэлэлцээрийг цааш хэрэгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, БНСУ-ын Гаалийн байгууллагын төлөөлөгчид Монгол Улсын гаалийн байгууллагад 2025 оны эхний хагас жилд томилолтоор ирж ажиллахаар тохиролцсон.<br>- Худалдаа хөрөнгө оруулалтын 6 дугаар хуралдаан үр дүнд “Үндэсний сургагч багш” нар бэлтгэгдсэн.<br>- “Говь” ХК, АПУ ХК, “Ханбогд кашимер” ХХК-ний ГИААН хөтөлбөрийн шалгуурын дагуу үнэлгээг хийсэн.<br>- “Их түмэн санаачилга”-ын Зөвлөлдөх комисст Монголын гаалийн байгууллагаас танилцуулсан “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн чадавхыг бэхжүүлэх” төсөл нь Гаалийн дэд хорооны 2024-2025 онд төлөвлөгөөндөө тусгагдсан.<br>- | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1.6 Агаарын тээврийн зорчигчийн мэдээллийг урьдчилан авч эрсдэл тооцож ажиллах боломжийг бүрдүүлнэ. Төмөр зам болон авто замын тээврээр зорчих зорчигчийн мэдээллийг ашиглан эрсдэл тооцох боломжийг бүрдүүлэхийн тулд Эрсдэлтэй зорчигчийг онилох системийн хөгжүүлэлтийг хийсэн байна. Зорчигчийн онилгооны төвтэй хамтран ажилласан байна. | Хэрэгжилт:<br>- Агаарын тээврийн зорчигчийн мэдээллийг урьдчилан авч эрсдэл тооцох APIS программ ашигласны төлбөрийг SITA-д ИНЕГ-аас төлдөг байсан боловч ИНЕГ-ын даргын 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 01/05 дугаартай албан бичгээр төлбөрийг төлөх боломжгүйг мэдэгдсэн. Үүнтэй холбоотой Гаалийн ерөнхий газрын ЗТАБГ-ЫН дарга Ж.Эрдэнэболд, Зорчигчийн мэдээллийн төвийн дарга А.Энхтөр тэргүүтэй төлөөлөгчдийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр уулзалт хийсэн.<br>- Гаалийн ерөнхий газар, Зорчигчийн мэдээллийн төвтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлж, “Мэдээлэл харилцан солилцох тухай гэрээ”-г 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан.<br>- Зорчигчийн мэдээллийн төвтэй ГЕГ мэдээлэл солилцох санамж бичгийн хүрээнд API болон PNR мэдээлэл солилцох боломж бүрдсэнтэй холбоотойгоор тухай мэдээллийг Кайс системд хөрвүүлэн ажиллуулах программыг нэвтрүүлсэнээр өөрсдөө эрсдэл тооцох боломж бүрдэх эсвэл бусад орны гаалийн байгууллагуудын ашигладаг программ хангамжийг авч API болон PNR мэдээллэлд ажиллах боломжийг бүрдүүлэх юм.<br>Хүрсэн түвшин:<br>- APIS программ ашигласны 2024 оны эхний 6 сарын төлбөрийг SITA-д ИНЕГ-аас төлсөн байна.<br>- Гаалийн байгууллага, НҮБ-ын террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан “Зорчигчийн мэдээллийн төв”-тэй цаашид мэдээлэл солилцох, мэдээллийн санг ашиглах, дүн шинжилгээ хийх чиглэлээр хамтран ажиллана.<br>- Зорчигчийн мэдээллийн төв өнөөдрийн байдлаар goTravel программаар МИАТ ТӨХК, Korean Air авиа компанийн зорчигчийн мэдээллийг туршилтаар ажиглах жагсаалтаар авч зорчигчийн жагсаалт үүсгэж онилгоог хийж байна. Жагсаалт тус бүрийг танилцуулж, мэдээллийг холбогдох байгууллагуудаар шалгуулж байна. Зорчигчийн мэдээллийн төв нь тухайн зорчигч дээр хүсэлт гаргахад нислэгийн мэдээлэл, түүхэн хайлт хийж мэдээлдэг. Зорчигчийн мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд эрсдэл бүхий 48 зорчигчийн мэдээллийг солилцож хамтаран ажиллаж байна. Мөн санд бүртгэлтэй зорчигчийн мэдээллийг эрх бүхий байгууллагуудад дамжуулдаг. Уг goTravel программын зорчигчийн мэдээллийг жагсаалтаар авч, эрсдэлтэй зорчигчийн онилгоог хийхээр хамтран ажиллаж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2** | Хууль сахилтын удирдлагын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аж ахуйн нэгж өөрийн хууль сахилтыг өөрөө үнэлдэг, гаалийн байгууллагатай хууль сахилтыг дэмжих чиглэлээр хамтран ажиллах боломжийг бүрдүүлхийн тулд хууль сахилтын эрсдэлийн удирдлагын программын даалгавар боловсруулна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Хяналтын төлөвийн хэрэгжилт, төлөв солилтын шалтгаан үр дүнг тооцно. | Бараанд хийх шалгалтаас чөлөөлөгдөх хувь хэмжээ: 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн гаалийн бүрдүүлэлт:<br>- Экспортын гаалийн бүрдүүлэлт: Бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 88% болж, өмнөх оны мөн үеэс 4%-иар өссөн байна. Мөн экспортын улаан төлөвийг 4%-иар бууруулжээ.<br>- Импортын гаалийн бүрдүүлэлт: Бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 18% байна.<br>- Нийт гаалийн бүрдүүлэлт: Бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 63% байна.<br>Тайлант хугацаанд (2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар) гаалийн системийн хэмжээнд нийт 1,109,566 гаалийн бүрдүүлэлт хийгдсэнээс импортын 400,834, экспортын 708,732 бүрдүүлэлт хийгдсэн байна. Хяналтын төлөвт сонгогдсон байдал:<br>Нийт гаалийн бүрдүүлэлт:<br>· Ногоон төлөв: 176,990 бүрдүүлэлт буюу 16%;<br>· Улбар шар төлөв: 523,330 бүрдүүлэлт буюу 47%;<br>· Улаан төлөв: 409,545 бүрдүүлэлт буюу 37%;<br>Импортын гаалийн бүрдүүлэлт:<br>· Ногоон төлөв: 12,306 бүрдүүлэлт буюу 3%;<br>· Улбар шар төлөв: 60,523 бүрдүүлэлт буюу 15%;<br>· Улаан төлөв: 328,005 бүрдүүлэлт буюу 82%;<br>Экспортын гаалийн бүрдүүлэлт:<br>· Ногоон төлөв: 164,384 бүрдүүлэлт буюу 23%;<br>· Улбар шар төлөв: 462,808 бүрдүүлэлт буюу 65%;<br>· Улаан төлөв: 81,540 бүрдүүлэлт буюу 12%.<br>Дүгнэлт: 2024 онд нийт 1,109,566 гаалийн бүрдүүлэлт хийгдсэнээс: Нийт дүнгээр: Улбар шар төлөвт 47%, улаан төлөвт 37%, ногоон төлөвт 16% сонгогдсон.Импортын бүрдүүлэлт: Улаан төлөвт 82% нь сонгогдсон нүүр тулсан харилцаа хэт өндөр, хяналт шалгалт энэ хирээр удаан явагдаж байна. Экспортын бүрдүүлэлт: Улбар шар төлөв 65%, ногоон төлөвт 23% сонгогдсон нь экспортыг дэмжих бодлого барьж байгаа харагдаж байна.<br>Цаашид: Импортын улаан төлөвийг бууруулж, хяналтыг оновчтой зохицуулалт хийх, Экспортод ногоон төлөвийг нэмэгдүүлж, гаалийн хяналтыг хялбаршуулах, экспортыг дэмжих.<br>Төлөв өөрчлөлтийн үр дүнг өмнөх онтой харьцуулахад: Ногоон төлөвт 45%, улбар шар төлөвт 79%-иар бууруулсан байна.<br>Төлөв өөрчлөлт: (Ногоон, улбар шар, улаан) 2024/2023 оны харьцуулалт:<br>Ногоон төлөв:<br>- 2023 онд: 45 (0.02%)<br>- 2024 онд: 25 (0.02%)<br>Өөрчлөлт: 2024 онд 2023 онтой харьцуулахад 45%-иар буурсан байна.<br>Улбар шар төлөв:<br>- 2023 онд: 213 (0.08%)<br>- 2024 онд: 45 (0.01%)<br>Өөрчлөлт: 2024 онд 79%-иар буурсан.<br>Засварт буцаалт:<br>- 2023 он: 3736 (0.41%)<br>- 2024 он: 2723 (0.25%) Өөрчлөлт: 27.13%-иар буурсан.<br>Баталгаажсаны дараа:<br>- 2023 он: 1320 (35.33%)<br>- 2024 он: 949 (34.85%) Өөрчлөлт: 28%-иар буурсан.<br>Баталгаажихын өмнө:<br>- 2023 он: 2416 (64.67%)<br>- 2024 он: 1774 (65.15%) Өөрчлөлт: 26%-иар буурсан. | 2024.01.01-12.10 | 100 |
| | | | | Эрсдэлийн судалгаа, дүн шинжилгээний үр дүнгээр бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдах ААНБ | 2024 оны эхний 11 сарын байдлаар Бүрдүүлэлтийн дараах шалгалтад тус хэлтсээс 302 ААН шалгах хүсэлт хүргүүлснээс нийт 58 аж ахуйн нэгж (ААН) хамрагдсан. Шалгалтын үр дүнд төсөвт 2.47 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,18 тэрбум төгрөг нь төлөгдөж, 1,28 тэрбум төгрөгийн акт төлөгдөөгүй байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | жагсаалтыг БДШГ-т хүргүүлж хамтран ажилласан байна. | Үүнээс:<br>- Зөрчил илэрсэн: 40 ААН<br>- Зөрчил илрээгүй: 12 ААН<br>- Хойшлогдсон: 1 ААН<br>- Дуусаагүй шалгалттай: 3 ААН<br>- Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн: 2 ААН<br>Үр дүнгээр боловсруулсан эрсдэлийн шалгуурын тоо:<br>БДШГ-аас 2024 онд 3 дотоод зурвас (81/24, 115/24, 185/24)-аар нийт 54 ААН-ийн эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт ирүүлсэн. Үүнээс 6 ААН нь 2023 оны эрсдэлийн шалгуурын программд хэрэгжиж байгаа тул 20 хяналтын хуудсаар, 48 эрсдэлийн шалгуурыг боловсруулсан. Үүнд:<br>- Заавал шалгах шалгуурт 12 хяналтын хуудсаар 40 ААН;<br>- Өндөр эрсдэлийн шалгуурт 4 хяналтын хуудсаар 4 ААН;<br>- Үл хамаарах шхалгуурт 2 хяналтын хуудсаар 2 ААН;<br>- Зөвшөөрөгдсөн шалгуурт 2 хяналтын хуудсаар 2 ААН-ийг эрсдэлийн шалгуурын программд оруулсан.<br><br>2024 онд Бүрдүүлэлтийн дараах шалгалтад эрсдэл тооцсон байдал:<br><br>2024 онд Эрсдэлийн удирдлагын хэлтсээс Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газарт 302 аж ахуйн нэгжийг шалгах хүсэлтийг 8 удаагийн дотоод зурвасаар хүргүүлсэн байна. Үүнд:<br>- 2023.10.30 (2023/144): Үлдсэн 15 ААН<br>- 2023.01.02 (2023/03): 45 ААН-аас үлдсэн 4 ААН<br>- 2024.01.25 (2024/17): 3 ААН<br>- 2024.02.06 (2024/25): 1 ААН<br>- 2024.02.21 (2024/32): 252 ААН<br>- 2024.04.08 (2024/63): 8 ААН<br>- 2024.05.10 (2024/92): 16 ААН<br>- 2024.06.04 (2024/106): 3 ААН<br>Шалгалтад хамрагдсан байдал:<br>- Төлөвлөгөөт шалгалтад: 39 ААН<br>- Төлөвлөгөөт бус шалгалтад: 18 ААН<br><br>Шалгалтын үр дүнгээр зөрчил гаргасан аж ахуйн нэгж болон хууль сахилт сайн аж ахуйн нэгжийг Эрсдэлтийн удирдлагын программд шалгуур үзүүлэлт боловсруулж оруулсан.<br>Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны үр дүнгээр харьяа гаалийн газар, хороодыг мэдээллээр хангасан байна.<br><br>Үр дүн: Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа хийх сургалт зохион байгуулж, харьяа гаалийн газар, хороодын оролцогчид өөрийн газар, хорооны 2023, 2024 оны эхний 10 сарын гаалийн бүрдүүлэлтийн мэдээлэл дээр ажиллаж, цаг хугацааны хэмжилт хийж, аргачлалыг сурсан. Энэхүү сургалтад хамрагдснаар гаалийн газар, хороод гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг илүү үр ашигтай, хурдан шуурхай болгоход туслах чухал алхам болсон.<br>Гаалийн байгууллагын “Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа 2023” -ны үр дүнгээр харьяа гаалийн газар, хороодын гаалийн улсын байцаагч нарын чадавхийг бэхжүүлэх сургалтыг ГЕГ-т 2024 оны 11 дүгээр сарын 5-6-нд зохион байгуулсан.<br>Энэхүү сургалт нь гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг илүү шуурхай, оновчтой болгох зорилготой бөгөөд оролцогчдод “Time Release Study” буюу барааг гаалийн хяналтад авснаас эхлэн хилийн чанадад гаргах хүртэлх хугацааг хэмжих аргачлал-ыг зааж сургасан. Сургалт танхим болон цахимаар нийт 50 гаруй гаалийн улсын байцаагч хамрагдсан.<br>Сургалтаар олгосон мэдээлэл, үр дүн:<br>- Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг сайжруулах: Оролцогчид гаалийн үйл ажиллагааны үе шат бүрд зарцуулж буй хугацааг хэмжих, үйл ажиллагааны үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлсон;<br>- Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилт: Гаалийн бүрдүүлэлтэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, саад тотгорын тухай ойлголтой болсон; | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Техникийн чадварыг бэхжүүлэх: Оролцогчид эксэл программ ашиглан өгөгдөл боловсруулах, алдаа засварлах, цаг хугацааны дараалалд мэдээллийг оруулах, бүрдүүлэлтийн горимыг шалгах зэрэг практик чадваруудыг эзэмшсэн.<br>Оролцогчид мөн ITDM төслийн баг-ийн дэмжлэгтэйгээр дэлхийн “Global trend TRS” болон МУИС, ГЕГ-ийн илтгэлтэй танилцсан. Мөн Tableau, хиймэл оюун ухаан ашиглан бүрдүүлэлтийн цаг хугацааг хэмжих аргачлал, CAIS программтай мэдээллээ хэрхэн нягтлан шалгах зэрэгтэй танилцсан. | | |
| **3** | Гадаад худалдааг хөнгөвчлөх | | - | 1. ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах Гаалийн ерөнхий газрын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулж, ЗББНДБ, гаалийн газар, хороодтой хамтран ажиллана. | - ГЕГ Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийг бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй уялдуулан өөрчилж, 2024 оны ажлын хэсгийн төлөвлөгөөг батлуулан ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодод хүргүүлсэн.<br>- ГЕГ-ын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгээс бусад зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангах зорилгоор Уул уурхайн бус тэргүүлэх салбарын 2024-2028 Үндэсний экспортын стратегийг Захиргаа, дотоод ажлын систем программын Худалдааг хөнгөвчлөх талбарт оруулсан.<br>- Монгол улс, БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЭЗТХ)-ийн анхны хэлэлцээ БНСУ-ын Сөүл хотноо 2023 оны 12 дугаар сарын 18-20 өдрүүдэд хуралдсан. Гаалийн журам ба худалдааг хөнгөвчлөх хэлэлцээний багийн анхны хурлын тайланг дотоод системд байршуулсан бөгөөд Гаалийн журам ба худалдааг хөнгөвчлөх бүлгийн баримт бичгийн төсөлд бусад бүтцийн нэгжүүдээс дотоод зурвасаар санал авч нэгтгэн боловсруулж, англи хэлнээс монгол хэлнээ орчуулж, ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>- Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороонд ГЕГ-ын худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн 2024 оны төлөвлөгөө, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргүүлсэн.<br>- Цахим худалдааг дэмжих, худалдааг хөнгөвчлөх зорилгоор НҮБ-ын Худалдаа Хөгжлийн бага хурлын төслийн багтай хамтран өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх, төслийн хүрээнд хүлээгдэж буй үр дүн, үр ашгийг тодорхойлох гаалийн байгууллагын үйл ажиллагаатай уялдуулахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг 2023.01.03-ны өдрийн Гаалийн Ерөнхий газрын даргын А/02 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газарт Гаалийн зарим үйл ажиллагааг автоматжуулахад дэмжлэг үзүүлнэ. НҮБ-ын ХХБХ-аас үзүүлэх техникийн туслалцааны зорилго нь гаалийн бүрдүүлэлтийг үр дүнтэй, түргэн хугацаанд хийх, цахим худалдаа, түүний дотор хил дамнасан худалдааны үйл ажиллагааг хөнгөвчлөх, улмаар төсвийн орлогын урсгалыг нэмэгдүүлэх, худалдааны луйвар гарах эрсдэлийг бууруулах, ГЕГ-ын бүхий л үйл ажиллагааг сайжруулахад оршино. Уг ажлын хэсгийн хүрээнд НҮБ-ын ХХБХ-тай 3 удаа цахим уулзалт хийж, 14 цахим захидал солилцож хамтран ажилласан. Төслийн хүрээнд туршилтын тест хийх боломжийг хангаң, Гаалийн байгууллагын мэдээллийн технологийн дэд бүтэц, сүлжээний хурд, гаалийн газар, хороодын өдрийн дундаж хяналтын мэдээлэл (тээврийн хэрэгсэл, манифест, гаалийн мэдүүлэг гэх мэт)-ийг 2022, 2023 оны байдлаар гарган өгсөн. АСИКУДА системийн цахим худалдаа (улс хоорондын шуудангийн илгээмж)-ны дэд модулийг манай улс цаашид хэрэглэх тохиолдолд хэрэгцээ шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргасан. Монголын гаалийн зарим үйл ажиллагааг дижиталчлах техник эдийн засгийн үндэслэлийн тайланг англи хэлнээс орчуулж, ГЗДАС-д байршуулж, ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодод түгээсэн.<br>- ЭЗХЯ, Олон улсын худалдааны төвөөс санаачилсан “Уул уурхайн бус барааны экспортыг нэмэгдүүлэх” стратеги боловсруулахад хамтран ажиллаж, 10 чиглэлийн хүрээнд боловсруулсан стратеги боловсруулах уулзалтад оролцон, төслийг ЗББНДБ-д түгээсэн. “Худалдааг хөнгөвчлөх стратеги”-ийг боловсруулах, орчуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт 252 албан хаагч дараах мэдээлэлтэй танилцсан байна.<br>- Их түмэн санаачилгын Гаалийн дэд хорооны 6 дугаар хуралдааныг Гаалийн ерөнхий газрыг төлөөлөн Эрсдэлийн удирдлагын хэлтэс даргалан, дэд хорооны 2024-2025 оны төлөвлөгөө, БНХАУ, БНСУ, ОХУ, Монгол Улсын Гаалийн байгууллагаас "Цахим худалдаа, цаасгүй худалдаа"-ны чиглэлээр хэрэгжүүлж буй тэргүүн туршлага, хүндрэлтэй асуудлыг хэрхэн даван туулсан арга замыг хуваалцахын зэрэгцээ Монголын Гаалийн байгууллагаас "Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийг танилцуулсан. | 2024.01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - НҮБ-ын Ази, Номхон Далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комиссын “Зүүн, хойд Азийн худалдааг хөнгөвчлөх олон улсын семинар”-т оролцож “Хил дамнасан цахим худалдаа Жижиг, дунд үйлдвэрлэлийн экспортод; Цахим ачааны дагалдах хуудас болон цахим худалдаа; Худалдааг хөнгөвчлөхөд технологийг хэрэглэх нь” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж, цаашид хэрэгжүүлэх арга замын талаар харилцан санал солилцсон. Энэхүү семинар нь Жижиг дунд үйлдвэрлэлийн экспортыг нэмэгдүүлэх, салбарын хөгжил, салбар хоорондын уялдаа холбоог хангахад дэмжлэг үзүүлэх чухал арга хэмжээ болсон.<br>- Хүрсэн үр дүн: Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хэрэгжүүлсэн ажилтай холбоотой 34 мэдээ, тайлан, судалгаа болон бусад бодлогын баримт бичгийг ГЗДАС-ийн “Худалдааг хөнгөвчлөх” дэд талбарт байршуулан (Хандалтын тоо 1,639), нэгж хоорондын уялдаа холбоог хангасан. Онцлог хүрсэн үр дүн дараах байдалтай байна:<br>- “Уул уурхайн бус барааны экспортыг нэмэгдүүлэх” стратеги төлөвлөгөө 10 дэд бүлгийн хамтаар батлагдсан. Стратегийг албан ёсоор ЭЗХЯ-аас ирүүлээгүй боловч “Худалдааг хөнгөвчлөх стратеги”-ийн хүрээнд тусгасан ажлыг ГЕГ-ын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгасан.<br>- Их түмэн санаачилгын Гаалийн дэд хороо, Худалдаа, хөрөнгө оруулалтын 6 дугаар хуралдаанд Монголын Гаалийн санаачилсан ИААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх шинэ төслийг танилцуулж, дэмжлэг авсан. Төслийг энэ оны сүүлийн хагас жилд зохион байгуулагдах Их түмэн санаачилгын Сайд нарын зөвлөлдөх зөвлөлийн уулзалтад танилцуулж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхээр болсон.<br>- Их түмэн санаачилгатай “Аж үйлдвэрийн парк бодлогын хэлэлцүүлэг; Зүүн, хойд Азийн Худалдааг хөнгөвчлөх олон улсын семинар зохион байгуулах; Бизнесийн нийгэмлэгтэй хамтран ажиллах” гэсэн чиглэлээр хамтран ажиллана.<br>- Монголын Гаалийн байгууллагаас санаачлан Их түмэн санаачилгын Гишүүн орнуудтай хамтран хэрэгжүүлсэн "Барааг дотоодод болон гадаад боловсруулах үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн гуравдугаар уулзалтын үеэр гарын авлагын төслийг боловсруулсан. Энэхүү төслийг 2024 оны сүүлийн хагас жилд боловсруулахаар төлөвлөсөн. Үүний үр дүнд далайд гарцгүй Монгол Улсын худалдаа эрхлэгч нарын хувьд дэлхийн эдийн засгийн нөлөө бүхий эдгээр орнуудад гадаадын, эсхүл дотоодын барааг Монгол Улсад боловсруулж, нэмүү өртөг шингэсэн барааг экспортолж гадаад зах зээлд нэвтрэн, эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.<br>- Худалдаа, хөрөнгө оруулалтын хорооноос Монгол Улсын Гаалийн байгууллагаас санаачлан танилцуулсан “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн чадавхыг бэхжүүлэх” төслийг дэмжсэн. Энэ оны 11 дүгээр сард зохион байгуулагдах Их түмэн санаачилгын Зөвлөлдөх комисст танилцуулан, төслийг батлуулахаар боллоо.<br>- • Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн ажилд хяналт тавих зорилгоор “Шинэчлэлийн хөтөч (Reform tracker)” программыг ашиглаж эхэлсэн. Үүнтэй холбогдуулан НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хуралтай хамтран ажиллах цахим уулзалтуудыг зохион байгуулсан. Эдгээр уулзалтын үр дүнд Меркатор хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө мөн Хямралын үед Худалдааг хөнгөвчлөхөд бэлэн байдлын үнэлгээний тайлан, үйл ажиллагаа зэргийг “Шинэчлэлийн хөтөч (Reform tracker)” программд оруулж, ашиглаж эхэлсэн нь Худалдааг хөнгөвчлөх ажлын шинэчлэлтийг сайжруулах томоохон хэмжээний ахиц дэвшил гарж байгааг харуулж байна. | | |
| | | | | 2.Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хүргүүлсэн байна. Нийт хэрэгжилт 87 хувьтай (Стратеги төлөвлөгөөнд төлөвлөсөн хэрэгжилтийн хувь 73) байна. | - Дэлхийн гаалийн байгууллагын “Меркатор” хөтөлбөр болон Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чадавхыг бэхжүүлэх онош зүйн шинжилгээний тайланг Гаалийн ерөнхий газрын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>- Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чадавхыг бэхжүүлэх, бусад арга хэмжээ, түүний дотор эрсдэлийн удирдлага, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөртэй уялдуулан хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>- Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр бүтэц орон тоог нэмэгдүүлж, өргөжүүлсэн.<br>- Гаалийн үнэлгээ, барааны ангилал, бүрдүүлэлтийн дараах шалгалтын чиглэлээр 14 албан хаагчийг Япон Улсын Токиогийн гаалийн төвд сургалтад хамруулж, мэдлэг чадварыг нь дээшлүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Бүрдүүлэлтийн дараах шалгалтын эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр ДГБ-ын экспертүүдийн тусламжтайгаар Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам, Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх зааврын шинэчлэн найруулсан төслийг боловсруулсан.<br>- Бүрдүүлэлтийн дараах шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч нарыг мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр Дэлхийн гаалийн байгууллагын бүрдүүлэлтийн дараах шалгалт, барааны гарал үүслийн сургалт, мөн Олон улсын валютыг сангаас зохион байгуулсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх сургалтад тус тус хамруулсан.<br>- Бүрдүүлэлтийн дараах шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч нарыг мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр тэдгээрт зориулсан тусгайлсан сургалтын хөтөлбөрийг боловсруулахаар ажиллаж байна.<br>- Энэ ажлын хүрээнд Эрсдэлийн удирдлагын хэлтсээс бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулах 303 аж ахуйн нэгж, иргэний мэдээллийг хүргүүлж, харилцан мэдээлэл солилцон хамтарсан эрсдэл тооцон ажиллах үйл ажиллагааг хэвшүүлсэн.<br>Хүрсэн үр дүн:<br>- Эрсдэлийн удирдлагад суурилсан бүрдүүлэлтийн дараах шалгалтыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, 303 аж ахуйн нэгжийн хууль сахилтыг тодорхойлж, холбогдох эрсдэлийн тодорхойлолт үүсгэн, худалдааг хөнгөвчлөхөд дэмжлэг үзүүлсэн. ГХЯ-нд хэрэгжилтийг хүргүүлж, Монгол Улсын ДХБ-ын өмнө авсан үүрэг амлалтыг 87.5 хувьд хүргэсэн. | | |
| | | | | 3.БНХАУ, БНСУ-тай байгуулсан Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр"-ийг хэрэгжүүлж эхлэсэн байна. БНХАУ, БНСУ болон бусад олон улсын байгууллагатай хамтран ажилласан байна. "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулах орон тоог 1-2-оор нэмэгдүүлэх саналыг хүргүүлсэн байна. | 3.1.Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулсан БНХАУ, БНСУ болон бусад олон улсын байгууллагатай хамтран ажилласан байна.<br>3.1.1.БНСУ, БНХАУ-ын гаалийн байгууллагатай ГИААН-ийн “Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр” (цаашид ХХЗХ)-ийг хэрэгжүүлэх хүрээнд мэдээлэл солилцох дараах 5 чиглэлийг 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 06 дугаар дотоод зурвасаар Гадаад хамтын ажиллагааны хэлтэст хүргүүлсэн. Үүнд:<br>- Аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгосны дараах Гаалийн байгууллага, ГИААН-ийн хамтын ажиллагаа;<br>- АЕО таних тэмдгийн талаарх мэдээлэл;<br>- Талуудын ГИААН-ийн мэдээллийг солилцох хэлбэр болон гаалийн хяналт, бүрдүүлэлтийн системд таних арга;<br>- ГИААН-ийн асуудлыг хариуцсан талуудын холбоо баригч нарыг томилох;<br>- БНСУ, БНХАУ-ын гаалийн байгууллагаас Монгол Улсын гаалийн байгууллагын итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид үзүүлэх хөнгөлөлт.<br>- ГХАХ-тэй хамтарч ажилласны үр дүнд БНСУ-ын Гаалийн байгууллагатай хамтарч дараах цахим уулзалт зохион байгуулагдсан.Үүнд:<br>· 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр БНСУ-ын Гаалийн байгууллагын ГИААН хөтөлбөр хариуцсан нэгжийн албан хаагчидтай цахимаар зохион байгуулсан уулзалт. Цахим уулзалтаар хэлэлцээрийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг идэвхжүүлэх, Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн мэдээллийг харилцан солилцох, эхний ээлжинд БНСУ-ын гаалийн байгууллагаас 3 ГИААН-ийн мэдээллийг Монгол Улсын гаалийн байгууллагад илгээх, Хэлэлцээрийг туршилтаар хэрэгжүүлж, үр дүнд үндэслэж 2 талаас албан ёсоор хэрэгжүүлэх хугацааг товлохоор тохиролцсон.<br>- Мөн тус гаалийн байгууллагатай цахим шуудангаар харилцан мэдээлэл солилцож ажилласны үр дүнд ХХЗХ-ийг хэрэгжүүлэх талаар цахим уулзалтыг 2024.11.19-ний өдөр зохион байгуулсан.<br>- БНХАУ-ын Гаалийн байгууллагатай цахимаар мэдээлэл солилцож хамтарч ажилласан. ГИААН хөтөлбөрийн талаар цахим шуудангаар мэдээлэл хүлээн авсан. Хятадын гаалийн байгууллагаас 3, Монголын гаалийн байгууллагаас 1 ГИААН-ийн мэдээллийг харилцан солилцсон.<br>3.1.2.Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC), Монгол Улсын гаалийн байгуулага хамтран Гаалийн Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (ГИААН)-ийн хөтөлбөрийг сайжруулах, тогтвортой болгох үндэсний семинар Улаанбаатар хотноо 2024 оны 4 сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.<br>- Уг семинарт бусад орны гаалийн байгууллагууд, тэдгээрийн дотор БНХАУ, БНСУ-ын гаалийн байгууллагын албан хаагчид цахимаар болон биечлэн оролцож, хөтөлбөр хэрэгжүүлэх | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | талаар Монгол Улсын ГХЯ, ЭЗХЯ, гаалийн байгууллагын төрийн албан хаагчид болон бизнесийн байгууллагуудын төлөөлөгчдөд мэдээлэл өгч, туршлагаа хуваалцсан.<br>- “ГИААН хөтөлбөрийн талаар 3 илтгэл бэлтгэж, сургалтад оролцогчдод танилцуулж, брошюр тараасан.<br>- Их түмэн санаачилгын Гаалийн дэд хорооны болон Худалдаа хөрөнгө оруулалтын 6 дугаар хуралдаан 2024 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулагдсан. Энэхүү арга хэмжээнд НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг нийгмийн комисс, Их түмэн санаачилгын Нарийн бичгийн даргын газар, БНХАУ-ын Худалдааны яам, БНСУ-ын Санхүү, эдийн засгийн яам, ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам, Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам, МҮХАҮТ болон Их түмэн санаачилгын гишүүн БНСУ, БНХАУ, ОХУ, Монгол Улсын Гаалийн байгууллагын давхардсан тоогоор 75 гаруй төлөөлөгчид оролцсон.<br>- Тус хуралдаанд ГЕГ-аас “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн чадавхыг бэхжүүлэх” төслийг Монголын гаалийн байгууллагаас танилцуулсан. Худалдаа, хөрөнгө оруулалтын хорооноос 2024 оны 9 дүгээр сард УБ хотноо зохион байгуулагдсан “Их түмэн санаачилга”-ын Зөвлөлдөх комисст танилцуулан, батлуулахаар шийдвэрлэсэн. Энэхүү төсөл нь Гаалийн дэд хорооны 2024-2025 онд төлөвлөгөөндөө тусгасан ЗУРГААН ажлын нэг юм.<br>Хүрсэн үр дүн:<br>- ХХЗХ-ийг хэрэгжүүлэх ажлыг хэрэгжүүлэхээр БНСУ , БНХАУ-ын гаалийн байгууллагааас тус бүр 3 ГИААН-ийн мэдээллийг хүлээн авч, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын мэдээллийг цахимаар илгээсэн.<br>- Хэлэлцээрийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, БНСУ-ын Гаалийн байгууллагын төлөөлөгчид Монгол Улсын гаалийн байгууллагад 2025 оны эхний хагас жилд томилолтоор ирж ажиллахаар тохиролцсон.<br>- Үндэсний сургагч багш нар бэлтгэгдсэн.<br>- “Их түмэн санаачилга”-ын Зөвлөлдөх комисст Монголын гаалийн байгууллагаас танилцуулсан “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн чадавхыг бэхжүүлэх” төсөл нь Гаалийн дэд хорооны 2024-2025 онд төлөвлөгөөндөө тусгагдсан.<br>3.2. "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулах орны тоог 1-2-оор нэмэгдүүлэх саналыг хүргүүлсэн байна.<br>- ОХУ-ын ХГА-ны Гаалийн хяналт бүрдүүлэлтийг зохион байгуулах төв газар, Гадаад хамтын ажиллагааны нэгжтэй 2024 оны 03 дугаар сарын 10-ны өдөр цахим уулзалт зохион байгуулсан. Энэхүү уулзалтаар 2 талын ГИААН хөтөлбөрийн талаар харилцан мэдээлэл солилцсон.<br>- Европын холбооны Монгол Улсын худалдааг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэгч багтай хамтран ажиллаж, ИААН хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх техникийн туслалцаа авах саналаа хүргүүлсэн.<br>Хүрсэн үр дүн:<br>- Монголын гаалийн байгууллагын 3 төлөөлөгч 2024 оны 12 дугаар сарын 16-21-ний өдрүүдэд ОХУ-ын ГИААН хөтөлбөрт хамрагдах аж ахуйн нэгжийн өөрийн үнэлгээг үнэлж, баталгаажуулах туршлагаас газар дээрээс нь суралцах бэлтгэл ажлыг хангаж байна.<br>- - Монгол Улсын худалдааг хөгжүүлэх төслийн 2025 оны төлөвлөгөөнд Европын холбооны улстай Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулах ажлыг судлан, харилцан туршлага судлах, сургалт зохион байгуулах | | |
| | | | | 4.ГИААН хөтөлбөрийг сурталчлан, таниулж, Гаалийн итгэмжлэлийг гадаад худалдаанд оролцогчдод 1-2 ААН-д итгэмжлэл олгох ажлыг зохион байгуулж, холбогдох програм хангамжийг хөгжүүлсэн байна. | 3.4.1. ГИААН хөтөлбөрийг сурталчлан, таниулсан байна.<br>- Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC), Монгол Улсын гаалийн байгуулага хамтран зохион байгуулсан ИААН-ийн хөтөлбөрийг сайжруулах, тогтвортой болгох үндэсний семинарт 3 сэдвээр илтгэл бэлтгэж, сургалтад оролцогчдод танилцуулж, брошюр тараасан. Монголын гааль цахим хуудсаар богино хэмжээний 11 бичлэг (7 reel, 4 video), ГБ-ын албан ёсны цахим хуудсаар 2 мэдээллийг тус тус олон нийтэд хүргүүлсэн.<br>- "Менежментийн форум-2024" арга хэмжээнд 2024.03.13-нд оролцож, бизнес эрхлэгчдэд "Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж" хөтөлбөрийн брошюр тарааж, Юнивишн, Юнител, Мобиком, Шангрила ХХК-ийн төлөөлөгчдөд хөтөлбөрийн талаар товч танилцуулж, зөвлөгөө өгсөн.<br>- УБГГ-аас албан бичгээр ирүүлсэн судалгаанд үндэслэж, Говь ХК, АПУ ХК, Сор кашимер ХХК, Ханбогд кашимер ХХК, Янмал ХХК-д "ГИААН хөтөлбөр"-ийн тухай болон | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөтөлбөрт хамрагдах боломжийн талаар 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 02-1/1534, 02-1/1535, 02-1/1536, 02-1/1537, 02-1/1538 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн.<br>- Дээр дурдсан ААН-үүдийн менежерүүдэд биет уулзалт, цахимаар болон утсаар удаа дараа холбоо барьж өөрийн үнэлгээний хуудсыг хэрхэн нөхөн бичих талаар зөвлөгөө өгсөн.<br>- Гадаад худалдаа эрхлэгчид, “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр”-т хамрагдахаар хүсэлт гаргасан ААН, ГЕГ-ын харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдыг арга зүй, зөвлөмжөөр хангах зорилгоор дараах сургалт, уулзалтад оролцож, танилцуулга хийж, холбогдох асуултад хариулсан. Үүнд:<br>· УБГГ-ын холбогдох удирдлагууд, ЭУА-ны албан хаагчид (8), ААН-ийн төлөөлөл (4) -тэй хийсэн уулзалт, сургалт. Нийт 12 хүн.<br>· “Говь” ХК-ийн удирдлагын төлөөлөл 9, “Ханбогд кашимер” ХХК-ийн ажилтнууд-5, УБГГ-ын ЭУА-ны 2 ГУБ.<br>· Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын хурлын танхимд, ЭУА-ны 6 ГУБ, ГУАБ, 21 ААН-ийн төлөөлөл.<br>- Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр (AEO)-т хамрагдах үйлчилгээний холбоос (https://gaali.mn/service/gaaliin-itgemjlegdsen-aj-akhuin-negj-khutulbur(aeo)-t-khamragdakh-khuselt--gargakh)-т хүсэлтийг хүлээн авах хугацаа (2 хоног гэснийг 3), хууль эрх зүй хэсгийн файл, холбоосыг нээгдэх боломжтой болгосон. Мөн “Үйлчилгээний танилцуулга”-ын Нэмэлт мэдээлэл хэсэгт “Гаалийн итгэмжлэгдсэн ААН-ийн жагсаалт”-ыг харах линк/холбоосыг нэмж оруулсан.<br>- Гаалийн байгууллагын албан ёсны цахим хуудас (https://customs.gov.mn/)-ын “Гаалийн хяналт, бүрдүүлэлт, зөрчил” хэсэгт ГИААН-ийн хөтөлбөрийн танилцуулга, эрх зүйн хэм хэмжээний акт, ГИААН-ийн жагсаалтыг оруулсан.<br>Хүрсэн үр дүн:<br>- Гаалийн харилцаанд оролцогчид ГИААН хөтөлбөрийн талаар мэдээлэл авч, хөтөлбөрт хамрагдах хүсэл эрмэлзлэлтэй болсон;<br>- “Говь” ХК, “АПУ” ХК, “Ханбогд кашимер” ХХК хөтөлбөрт хамрагдахаар хүсэлтээ гаргасан.<br>- 3.4.2 ААН-д итгэмжлэл олгох ажлыг зохион байгуулсан байна.<br>- УБГГ-аас албан бичгээр ирүүлсэн судалгаанд үндэслэж, Говь ХК, АПУ ХК, Сор кашимер ХХК, Ханбогд кашимер ХХК, Янмал ХХК-д "ГИААН хөтөлбөр"-ийн тухай болон хөтөлбөрт хамрагдах боломжийн талаар 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 02-1/1534, 02-1/1535, 02-1/1536, 02-1/1537, 02-1/1538 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн.<br>- Дээр дурдсан ААН-үүдийн менежерүүдэд биет уулзалт, цахимаар болон утсаар удаа дараа холбоо барьж өөрийн үнэлгээний хуудсыг хэрхэн нөхөн бичих талаар зөвлөгөө өгсөн.<br>- Гадаад худалдаа эрхлэгчид, “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр”-т хамрагдахаар хүсэлт гаргасан ААН, ГЕГ-ын харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдыг арга зүй, зөвлөмжөөр хангах зорилгоор дараах сургалт, уулзалтад оролцож, танилцуулга хийж, холбогдох асуултад хариулсан. Үүнд:<br>· УБГГ-ын холбогдох удирдлагууд, ЭУА-ны албан хаагчид (8), ААН-ийн төлөөөлөл (4) -тэй хийсэн уулзалт, сургалт. Нийт 12 хүн.<br>· “Говь” ХК-ийн удирдлагын төлөөлөл-9<br>· “Ханбогд кашимер” ХХК-ийн ажилтнууд-5, УБГГ-ын ЭУА-ны 2 ГУБ.<br>“Говь” ХК, “АПУ” ХК, “Ханбогд кашимер” ХХК-д Гаалийн итгэмжлэл олгох шалгуурыг үнэлэх, баталгаажуулах ажлын удирдамжийг боловсруулж, удирдлагаар батлуулсан. Удирдамжаар нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг байгуулсан.<br>Хүрсэн үр дүн:<br>· “Говь” ХК, “АПУ” ХК, “Ханбогд Кашимер” ХХК-д Гаалийн итгэмжлэл олгох шалгуурыг үнэлэх, баталгаажуулах ажлыг удирдамжийн дагуу зохион байгуулсан. Баталгаажуулалтын үр дүнг ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлд танилцуулахаар бэлтгэл ажлыг хангасан.<br>3.4.3.Холбогдох программ хангамжийг хөгжүүлсэн байна.<br>ГИААН хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Аствишн ХХК-ийн мэргэжилтэнүүдтэй хамтарч дараах программуудад өөрчлөлт оруулсан. Үүнд: | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | · Гаалийн цахим үйлчилгээний системийн Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр (АЕО)-т хамрагдах үйлчилгээтэй холбоотой программ;<br>· Гаалийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл, хяналтын программ.<br>-Гаалийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл, хяналтын программд:<br>· Хянах самбарт хүсэлтийн төлвийн нэрийг өөрчилсөн.<br>· "Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам"-д нийцүүлж, хүсэлт хүлээн авсан, хүсэлт буцаасан төлвийн нэрийг тус тус оруулсан.<br>· ААН-ээс “Буцаасан хүсэлт”-ийг дахин илгээхэд “шинэ хүсэлт” төлөвтэй хянах самбарт харагдаж, шинэ дугаараар бүртгэгдсэн алдааг залруулсан.<br>· Удирдамж хэсэгт ГЕГ-ын ЗББНДБ, ГГХ-д, тэдгээрт харьяалагдах албан хаагчдыг шалгалтын бүрэлдэхүүнд оруулах, дэлгэцэнд харагдах, удирдамжийг засварт буцаах боломжтой болсон.<br>· БДШ-ын программын Аж ахуйн нэгжийн мэдээлэл (ААН-ийн мэдээлэл-11, Гаалийн бүрдүүлэлт, хууль сахилт-6) хэсгийг энэхүү бүртгэл, хяналтын программд татаж, мэдээллийг хяналтад ашиглах, ААН-ийн мэдээллийг Хурын мэдээлэлтэй жиших боломжтой болсон.<br>· ААН-ийн хүсэлтийг хүлээн аваад, бичиг баримтын бүрдлийг шалгах шатанд ААН-ийн хавсаргаж илгээсэн бичиг баримтыг программд харах боломжтой болсон.<br>· Өөрийн үнэлгээг үнэлж, баталгаажуулах явцад, ААН-ээс бичиг баримтыг программд нэмж оруулах хүсэлтийг илгээж, хүлээн авах боломжтой болсон.<br>· ААН-ийн цахимаар ирүүлсэн өөрийн үнэлгээг хүлээн авч, бичиг баримтын болон ажлын байрны баталгажуулалтыг программд хийх боломжтой болсон. (өмнө нь бичиг баримтын болон ажлын байрны баталгаажуулалтын үед эксэл файлыг ашиглаж, үнэлгээ хийж, эцэслэн мэдээллийг программд оруулж, баталгаажуулдаг байсан)<br>-Гаалийн цахим үйлчилгээний системийн Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр (АЕО)-т хамрагдах үйлчилгээтэй холбоотой хэсэгт:<br>· Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр (АЕО)-т хамрагдах үйлчилгээ (https://gaali.mn/service/gaaliin-itgemjlegdsen-aj-akhuin-negj-khutulbur(aeo)-t-khamragdakh-khuselt--gargakh) холбоост хүсэлтийг хүлээн авах хугацаа (2 хоног гэснийг 3), хууль эрх зүй хэсгийн файл, холбоосыг нээгдэх боломжтой болгосон. Мөн “Үйлчилгээний танилцуулга”-ын Нэмэлт мэдээлэл хэсэгт “Гаалийн итгэмжлэгдсэн ААН-ийн жагсаалт”-ыг харах линк/холбоосыг нэмж оруулсан.<br>· Гаалийн байгууллагын албан ёсны цахим хуудас (https://customs.gov.mn/)-ын “Гаалийн хяналт, бүрдүүлэлт, зөрчил” хэсэгт ГИААН-ийн хөтөлбөрийн танилцуулга, эрх зүйн хэм хэмжээний акт, ГИААН-ийн жагсаалтыг оруулсан. | | |
| **Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | | | |
| **4** | Арга хэмжээ 1.2 Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн найруулж, төслийг боловсруулсан байна. | Хэрэгжилт:<br>БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (КОЙКА)-ийн буцалтгүй тусламжаар “Монгол улсын Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын мэдээллийн системийг боловсронгуй болгох, шинэчлэх, чадавхыг бэхжүүлэх төсөл” 2025-2028 онд хэрэгжихээр болсон. Энэхүү төслийн хүрээнд хийгдэх эрсдэл тооцох программ, Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын стратеги, ДГБ-ын “Эрсдэлийн удирдлагын компендиум”, Стандарт, хэмжил зүйн газрын “MNS ISO 31000:2020, Эрсдэлийн менежмент. Удирдамж” болон бусад хууль тогтоомжтой уялдуулан, “Гаалийн хяналтад эрсдэл тооцох аргачлал”-ыг “Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”, хорио цээрийн хяналтад эрсдэл тооцох аргачлалтай нэгтгэн төслийг боловсруулж, удирдлагад танилцуулсан. Үүнтэй “Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-ын шинэчлэлийг төслийн эрсдэлийн удирдлагын мэдээллийн системтэй нийцүүлэх шаардлагаар хойшлуулж, нэмэлт өөрчлөлт оруулахаар болсон.<br>ГЕГ-ын МЗХ-д Эрсдэлийн удирдлагын программд оруулах “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”-ийг ГЕГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/287 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-ын 3.8 дахь хэсгийн 3.8.5 дахь хэсэгт “эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг гаалийн улсын байцаагч боловсруулж, хяналтын хуудас бүхий маягтыг бөглөж, баталгаажуулан тухайн эрсдэлийн профайлд хавсаргах” гэдэгт нэмэлт, өөрчлөлт оруулж, хавсралтаар батлуулав. | 2024.01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төсөл хэрэгжүүлэх багтай ГЕГ-ын дарга, дэд дарга, ЗУГ, МТГ, ГХАХ, ЭУХ-ийн дарга нар уулзаж, төслийн хүрээнд хийгдэх ажлын талаар харилцан санал солилцон ажиллаж байна. ГЕГ-ын даргын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/624 дүгээр тушаал, төсөв, уулзалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулсан. БНСУ-ын КОИКА байгууллагын техник эдийн засгийн судалгаа хийх багтай 2024 оны 11 дүгээр сарын 24-нөөс 30-ныг хүртэл хамтран ажилласан. СЯ, ГЕГ-ын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын газар, хэлтсийн удирдлага, холбогдох албан хаагч, УБГГ, гаалийн зуучлагч, тээвэрлэгчдийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, ЧХОУНБГГ, УБГГ, Туушин терминал, ШХТ-ийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцуулсан. Мөн тайлангийн хурал зохион байгуулж ажилласан. Төслийн багийнхантай хамтран ажиллаж “Эрсдэлийн удирдлагын программ хангамжийг боловсронгуй болгох” санал гаргасан (Хавсралт-1)<br>Хүрсэн түвшин:<br>“Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-д “Эрсдэлийн удирдлагын программын эрсдэлийн шалгуур”-ыг ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороод “Эрсдэлийн шалгуурын хүсэлт” маягтын дагуу бөглөнө. Тус маягтаар ирүүлсэн санал болон эрсдэлийн дүн шинжилгээнд үндэслэн Эрсдэлийн удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлуулж, программд оруулахаар шийдвэрлүүлж, журамд нэмэлт өөрчлөлт оруулсан.<br>КОЙКА АЖЛЫН ХЭСЭГ: Эрсдэлийн удирдлагын программ хангамжийг боловсронгуй болгох санал:<br>Эрсдэлийн удирдлагын системийг шинээр боловсруулах (Хиймэл оюун ухааныг ашиглах);<br>Эрсдэлийн шалгуурыг автоматжуулах;<br>Эрсдэл тооцох, дүн шинжилгээ хийх аргачлалыг автоматжуулах;<br>Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн программыг сайжруулж;<br>Эрсдэлийн удирдлагын программын шалгуурт оруулж хөгжүүлэх;<br>Хууль сахилтын программыг нэвтрүүлэх;<br>Хиймэл оюун ухаанд суурилсан урьдчилан таамаглах системийг хөгжүүлэх, ISO 27001, ISO 31000 стандартыг нэвтрүүлэх;<br>Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх гэсэн өөрчлөлтийг хийх тул одоогийн мөрдөж буй “Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-ыг программтай нийцүүлэх шаардлага үүссэн. | | |
| | | | | Эрсдэлийн удирдлагын чиглэлээр холбогдох бусад бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тухай бүр тайлагнасан байна. | Хэрэгжилт:<br>- Засгийн газрын 2023.05.17-ны өдрийн 178 дугаар тогтоолын биелэлтийг дараах заалтуудын дагуу Хуулийн хэлтэст сар бүр, Хяналт, бүрдүүлэлтийн газарт улирал бүр, 2024 оны эхний хагас жилийн байдлаар тус тус гаргаж, цаг хугацаанд нь хүргүүлсэн: (Дотоод зурвас: 2024/15; 2024/40; 2024/52; 2024/82; 2024/178; 2024/184)<br>- Эрсдэлд суурилсан гаалийн хяналтыг эрчимжүүлж, мэдээлэл, бичиг баримтын болон бараа, тээврийн хэрэгсэлд хийх шалгалтад хамрагдах гаалийн бүрдүүлэлтийн тоог жил бүр 15 хувиар бууруулж, гадаад худалдааг хөнгөвчлөх, хилийн боомт дээр дараалал, бөөгнөрөл үүсгэхгүйн тулд бараа, тээврийн хэрэгслийг гүнийн гаалийн хяналтад шилжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч ажиллах;<br>- Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гаалийн байгууллага хооронд байгуулсан “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх;<br>- “Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуй нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам”-д заасан аж ахуйн нэгжид тавигдах шаардлагыг оновчтой болгох, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах.<br>- Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 178 дугаар тогтоол, Гаалийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт зэрэг бодлогын бичиг баримт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зөвлөмжийн дагуу биелэлтийг гаргаж, цаг хугацаанд нь тайлагнасан.<br>- “ГЛОБАЛ ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ ХӨТӨЛБӨР (GTFP)”-ийн II үе шат. Төслийн баг 2024 оны 10 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд Гаалийн ерөнхий газарт ажиллаж, Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын стратеги төлөвлөлтийн чадавхыг бэхжүүлэх, ДГБ-ын Гүйцэтгэлийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалгуур үзүүлэлтийн механизмын дагуу гүйцэтгэлийн хэмжүүрийг сайжруулах, хөгжүүлэхээр “Стратегийн төлөвлөгөө ба Гүйцэтгэлийн хэмжүүр” семинарыг зохион байгуулсан.<br>- “Гаалийн үйл ажиллагааг сайжруулах замаар илүү сайн үйлчилгээ үзүүлэх” төслийн хүрээнд КАРЕК-ийн орнуудын худалдааг хөнгөвчлөх, түүний дотор ИААН хөтөлбөрийн бэлэн байдлыг дэмжихэд чиглэсэн “Сургагч багш” нарыг бэлтгэх, Төр-Хувийн хэвшлийн чадавхыг бэхжүүлэх үндэсний семинарыг зохион байгуулсан.<br>Хүрсэн түвшин:<br>- Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг сайжруулах, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг хэрэгжүүүлэхэд дэмжлэг болох судалгаа, дүн шинжилгээг тогтмол хийж, дараагийн хагас жилд хэрэгжүүлэх ажлаа төлөвлөх нөхцөл бүрдүүлсэн. ЭЗХЯ, СЯ-ыг худалдааг хөнгөвчлөх чиглэлээр мэдээллээр хангасан.<br>- “ИААН хөтөлбөрийг сайжруулах, тогтвортой болгох үндэсний семинар”-ын үр дүнд 50 “Сургагч багш”-тай болсон.<br>- ДГБ-Швейцарийн Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын хамтарсан “Глобал худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр (GTFP)”-ийн хоёрдугаар үе шатанд Монголын Гаалийн байгууллага хамрагдах болсон тул, худалдааг хөнгөвчлөх зарим арга хэмжээтэй уялдуулсан. | | |
| **5** | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох ажлын хүрээнд нэгжийн эрсдэлийг таньж тогтоож, сан үүсгэхэд хэлтсийн албан хаагчидтай хамтарч ажилласан байна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож, сан үүсгэсэн байна. | 1.Нэгжийн гүйцэтгэлийг давхардалгүй, орхигдуулахгүй, үр дүнтэй зохион байгуулахад учирч болзошгүй эрсдэлийг таньж, тогтоон түүнийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор тус хэлтсийн “Бүтэц, зохион байгуулалт; Хүний нөөц; Мэдээллийн технологи; Сүүлийн 5 жилд эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтыг нэвтрүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл” зэргийг харьцуулан судалж, олон хүчин зүйлийн нөлөөллийг гаргахын зэрэгцээ, ганцаарчилсан болон фокус ярилцлага хийж болзошгүй эрсдэлийн санг үүсгэсэн.<br>2. Системийн хэмжээнд “Байгууллагын дотоод эрсдэл тооцох” ажлын хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн зөвлөмж дутагдалтай байгаа тул ЭУХ, ЗУГ, ХШҮДАГ-тай хамтран ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газрын төлөөллийг оролцуулсан сургалт, уулзалтыг нэгдсэн, фокус хэлбэрээр зохион байгуулж, дараах байдлаар ажилласан:<br>- Гаалийн ерөнхий газрын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодыг оролцуулсан “Байгууллагын эрсдэл тооцох” мэргэшүүлэх сургалт, уулзалт зохион байгуулсан;<br>- “Хууль эрх зүй; Институци/Захиргааны зохицуулалт; Хүний нөөц, Сургалт болон Төсөв санхүү; Хамтын ажилллагаа болон Мэдээлэл солилцоо; Технологийн дэмжлэг” таван чиглэлээр байгууллагын эрсдэл тооцсон;<br>Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн дүн шинжилгээ хийхдээ ДГБ-ын Эрсдэлийн удирдлагын компендиумд үзүүлсэн үйл ажиллагааны зураглалын дагуу хийж гүйцэтгэсэн. Эрсдэлийн агуулгыг тодорхойлох зорилгоор судалгааны 2.1 дэх хэсэгт үзүүлсэн асуултад хариулахын тулд зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодтой ганцаарчилсан болон фокус ярилцлага, төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулан судалж, хувьсамтгай орчны болон SWOT шинжилгээг хийж гүйцэтгэсэн.<br>Эрсдэлийн тооцоо хийж, таван чиглэлийн хүрээнд тодорхойлсон 27 эрсдэлийг бүртгэн, магадлал, үр дагаврын үржвэрээр тоон илэрхийлэлд оруулж, эрсдэлийн үнэлгээ хийхэд ерөнхий дунджаар “өндөр” эрсдэлтэй байв. Эдгээрийн 17 буюу 63 хувь нь өндөр, 7 буюу 26 хувь нь дунд, үлдсэн 3 буюу 11 хувь нь бага эрсдэлийн түвшинд байна.<br>Эдгээрээс “Мэдээллийн технологи”; “Хүний нөөц, сургалт болон санхүү”, “Хууль тогтоомж”-той холбоотой эрсдэлийн зэрэглэл өндөр, “Харилцаа холбоо” болон “Захиргаа/институци”-тэй холбоотой эрсдэлийн зэрэглэл дунд гэж үнэлэгдсэн байна. Гэхдээ чиглэл тус бүрийн хүрээнд тодорхойлсон эрсдэлийг бууруулахын тулд байгууллагын хамт олон өөрсдөө хүчин чармайлт гарган, эрсдэлийг бууруулах боломжийг эрэлхийлж байна.<br>ДГБ-ын Эрсдэлийн удирдлагын компендиумд тусгасан эрсдэлийг бууруулах “Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх (tolerate); Эрсдэлтэй тулж ажиллах (treat);Эрсдэлийг шилжүүлэх (transfer)” зарчмаар ажиллан 2.2.4 дэх хэсэгт эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг гаргасан.<br>ДГБ-ын Эрсдэлийн удирдлагын компендиумд тусгасан эрсдэлийг бууруулах “Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх (tolerate); Эрсдэлтэй тулж ажиллах (treat);Эрсдэлийг шилжүүлэх (transfer)” зарчмаар ажиллан хавсаргасан судалгааны 2.2.4 дэх хэсэгт эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хамтран гаргасан.<br>Эрсдэлийн тооцооны үр дүнгээр таван хүчин зүйлийг ач холбогдлоор нь эрэмбэлэн, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг тэргүүлэх чиглэлийн, өндөр болон дунд эрсдэл тус | 2024.01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүрээр гарган 33 арга хэмжээг төлөвлөн, байгууллагын шинэ стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт хүргүүлсэн. | | |
| **6** | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Хөрөнгө орлогоо мэдүүлбэл зохих төрийн тусгай албан хаагчийн ХАСХОМ-ийг мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд гаргаж, 100 хувь баталгаажуулсан байна. | Хэрэгжилт:<br>Хөрөнгө орлогоо мэдүүлбэл зохих 8 албан хаагчид ХАСХОМ-ийг бүрэн мэдүүлж, баталгааны маягтыг хуулийн хугацаанд гаргаж, 100 хувь баталгаажуулсан. ХАСХОМ хариуцсан ЭБАТ-нд баталгааны маягтыг хүлээлгэн өгсөн.<br>ХАСУМ-ийг 3 албан хаагч хугацаанд нь холбогдох маягтын дагуу гаргасан. | 2024.01.01-12.10 | 100 |
| **7** | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлнэ. | Хэрэгжилт:<br>ЭУХ-ийн албан хаагч нар 2024 оны жилийн эцсийн байдлаар удирдлагын шуурхай хуралдаанаас болон бусад өгсөн 9, бусад 27 удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажилласан:<br>1. Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг ашиглах, хэрэглэхтэй холбоотой зөрчлүүд сүүлийн үед ихээр гарч байгаа тул Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны А/251 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх журам”-ын хэрэгжилтийг хангах, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг зохион байгуулж ажиллахыг үүгээр мэдэгдэж байна.<br>2. ГЕГ-ын даргын 2022 оны А/226 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 2.13 дахь заалтыг үндэслэн нийт ажилтан, албан хаагчдад зориулсан “Мэдээллийн цаг”-ийг 14 хоног тутамд нэг удаа зохион байгуулахаар төлөвлөн ажилласан.<br>3. 2024 оны эхний мэдээллийн цагийг 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 09.00 цагт зохион байгуулсан бөгөөд ирцийн байдал хангалтгүй байна. Иймд “Үүрэг даалгавар”-ын программаар улирал бүр нийт албан хаагчдын мэдээллийн цагт хамрагдсан байдлыг харгалзан үзэж, дүгнэхээр болсон тул албан хаагчдаа бүрэн идэвхтэй хамруулж ажиллахыг үүрэг болгож байна.<br>4. Гаалийн байгууллагаас 2024 онд дэвшүүлсэн “Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, хамтын ажиллагааг өргөжүүлэх”, “Цахим шинэчлэлд суурилсан ил тод, шуурхай төрийн хяналтыг хэрэгжүүлэх”, “Мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцийг бүрдүүлж, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоог бий болгох” зорилтуудын хүрээнд Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/69 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт”, 2021 оны А/251 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам”-ыг нийт албан хаагчиддаа танилцуулах ажлыг шуурхай зохион байгуулж, хавсралтаар хүргүүлсэн хүснэгтийн дагуу гарын үсгээр баталгаажуулан 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн дотор ирүүлэх, мөн журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгож байна.<br>5. “Үүрэг даалгавар”-ын программаар улирал бүр нийт албан хаагчдын мэдээллийн цагт хамрагдсан байдлыг харгалзан үзэж, дүгнэхээр болсон тул албан хаагчдаа бүрэн идэвхтэй хамруулж ажиллахыг үүрэг болгож байна.<br>6. 2024 оны сургалтын төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 07-ны дотор цаг хугацаанд нь оруулах.<br>7. Олон улсын гаалийн өдрийн тохиолдуулан “Гаалийн байгууллага 2024 онд” танилцуулга.<br>8. Монголын Эдийн Засгийн Чуулган-Бүсчилсэн Хөгжлийн Зөвлөгөөн.<br>9. "Менежментийн форум-2024" арга хэмжээ.<br>10. Эмэгтэйчүүдийн манлайлал.<br>11. ДГБ-аас зохион байгуулсан "Гарал үүсэл" Үндэсний сургалт.<br>12. “Худалдааг хөнгөвчлөх нь” сэдэвт хэлэлцүүлгийн бэлтгэл ажлын талаарх урьдчилсан уулзалт.<br>13. “Цахим засаглалын төлөв, цаашдын чиг хандлага (кибер аюулгүй байдал)” сэдэвт сургалт Худалдан авах үйл ажиллагаа.<br>14. Стандартчиллын суурь асуудлууд.<br>15. “ЗҮГГ-т хийгдсэн гаалийн бүрдүүлэлттэй холбоотой эрсдэлт орчин”-г бууруулах судалгаа хийх. | 2024.01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 16. НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Зүүн хойд Азийн Худалдааг хөнгөвчлөх олон улсын семинар.<br>17. Их түмэн санаачилгын Гаалийн дэд хорооны 6 дугаар хуралдаан.<br>18. Их түмэн санаачилгын Худалдаа хөрөнгө оруулалтын 6 дугаар хуралдаан.<br>19. “Цахим худалдаанд дэмжлэг үзүүлэх хэлэлцүүлэг”-т оролцох.<br>20. ДГБ-ын болон Швейцарийн Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын (SECO)-ын хамтарсан “Глобал худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр” (GTFP)-ийн семинарт оролцох.<br>21. ГЕГ-ын төв байр болон ГТЛ-ийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой санамжийг мөрдөж ажиллах.<br>22. Худалдааг хөнгөвчлөх, гаалийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээг түргэн шуурхай болгох, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар 2024 онд хийж хэрэгжүүлсэн онцлог ажил, үр дүн.<br>23. Гаалийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөл оруулах санал ирүүлэх.<br>24. ДГБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас зохион байгуулах Цахим худалдааны багцын салбар дундын анхны онлайн уулзалтад оролцох.<br>25. Гаалийн баярт оролцох албан хаагчдын нэр, тоог ирүүлэх.<br>26. Хуулийн давхардал хийдлийн судалгаа, санал ирүүлэх.<br>27. Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөлд тусгах алсын хараа, зорилго, зорилтын санал.<br>28. Нийт албан хаагчид цаг бүртгэлийн төхөөрөмжид цагаа бүртгүүлэх тухай.<br>29. Сангийн сайдын 22 дугаар тушаалын хэрэгжилтэд ХШДАГ-аас хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай.<br>30. Авилгатай тэмцэх газраас ирүүлсэн 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 138 дугаартай мөрдөгчийн мэдэгдлийг нийт албан хаагчдад танилцуулах.<br>31. Мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх үйл ажиллагааны сургалтад хамруулах тухай.<br>32. Tableu desktop программын анхан болон дунд шатны сургалтад хамруулах тухай.<br>33. ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 68 дугаартай Мөрдөгчийн мэдэгдлийг нийт албан хаагчдад танилцуулах тухай.<br>34. Жендерийн үндэсний хорооны Ажлын албанаас зохион байгуулах МУ-ын ЕС-ын 2024 оны 71 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2024 он)-г танилцуулах арга хэмжээнд оролцох.<br>35. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг рентген хяналтаар таньж илрүүлэх сургалтад хамруулах.<br>36. Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөлд тусгах санал.<br>Хүрсэн түвшин:<br>- Удирдлагын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлэн, хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>- Худалдааг хөнгөвчлөх, цахим худалдаа, Эдийн засгийн зөвлөгөөн, Гарал үүслийн сургалтад гурван модулийн орчуулга хийж оролцон, гарал үүслийн луйвар гаргах эрсдэлийг таньж тогтооход дэмжлэг болсон.<br>- ГЕГ-ын дарга, дэд даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу холбогдох ажлын хэсэгт орж ажиллан, үр дүнг тухай бүр танилцуулж, холбогдох тайлан ГЗДАС-д байршуулсан. | | |
| | | | | ХГГХ-д хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна. | Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний арга хэмжээнээс чиг үүргийнхээ хүрээнд 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулсан ба харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад зөвлөмж чиглэлээр хангаж, зорилтот түвшинг тодорхой бодитой, улирал бүрт зөв хуваарилан төлөвлөхөд дэмжлэг үзүүлсэн. Харьяа гаалийн газар, хороодод дараах 8 үүрэг даалгаврыг ГЗДАС программаар хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.<br>- Гаалийн хяналтын төлөвийн дагуу шалгалтын үр дүнг хэрхэн оруулсан судалгааг эхний улирлаар ирүүлэх,<br>- Монгол Улсын ГЕГ, ОХУ-ын ХГА хоорондын эрсдэлийн удирдлагын хүрээнд хамтран ажиллах тухай хэлэлцээрийг хэрэгжүүлэх анхдугаар уулзалттай холбогдуулан мэдээл ирүүлэх,<br>- "Ёс зүй, жендэрийн эрх тэгш болон олон талт байдал" чиглэлээр 2024 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн ажлын тайлан, хүндрэлтэй асуудал, цаашид хэрэгжүүлэх ажлын санал ирүүлэх, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - ДГБ-ын “Байгууллагын Жендэрийн эрх тэгш болон ялгаатай байдлыг үнэлэх заавар” болон бусад материалтай танилцах,<br>- Бусад байгууллагын ёс зүйтэй холбоотой баримтыг судлан санал ирүүлэх,<br>- Нэгжийн эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэх сургалтад хамруулах,<br>- Гаалийн байгууллагын Ёс зүйн чиглэлээр Үйлчлүүлэгчээс авах санал асуулга авах,<br>- Ухаалаг гарцын системийн талаар санал, судалгаа ирүүлэх.<br>Гаалийн мэдүүлгийн шалгалтын үр дүнгийн саналд дүн шинжилгээ хийж, санал бичилтийг үр дүнтэй бичүүлж хэвшүүлж, эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох зорилгоор судалгааны формат гарган, гаалийн газар, хороодод хүргүүлж, мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан.<br>ОХУ-тай хиллэдэг УВГГ, ДОГГ, СЭГГ, ЗАГХ, ХӨГХ, БӨГГ, УБГГ-аас биелэлт илгээж, холбогдох саналыг авч хамтран ажилласан. “Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газар, Оросын Холбооны Улсын Холбооны Гаалийн Алба Хоорондын Эрсдэлийн Удирдлагын хүрээнд хамтран ажиллах тухай 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хэлэлцээр” (Цаашид “Эрсдэлийн удирдлагын хэлэлцээр” гэх)-ийн хэрэгжилтийг хангах асуудлаар шинжээчдийн анхдугаар уулзалтыг 2024 оны 06 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд ГЕГ-т зохион байгуулж, төлөвлөгөөг 9 асуудлаар боловсруулан, дараагийн уулзалтыг 2025 онд ОХУ-д зохион байгуулахаар болсон.<br><br>Хүрсэн түвшин:<br>Харьяа гаалийн газар, хороодод эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч, хамтран ажилласан.<br>ГУБ нарын шалгалтын үр дүнгийн санал бичилт сайжирч байна. Судалгаанд тоймлон оруулсан болно. ЗУГ-аас ГУБ-ийн ажлын үр дүнг тооцоход шалгалтын үр дүнгийн санал бичилтийг нэг шалгуур үзүүлэлт болгохоор болсон.<br>Бичиг баримт хариуцсан ГУБ болон хяналт, шалгалт хариуцсан ГУБ нараас ирүүлсэн ААН болон гаалийн мэдүүлэгт бүрдүүлэлтийн дараах шалгалт оруулах саналыг судалж, БДШГ-т дотоод зурвасаар хүргүүлж хэвшсэн.<br>Хэлтсийн дарга ГЕГ-ын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны даргаар сонгогдсоноор тус хэлтсийн ачаалал нэмэгдэж, Байгууллагын эрхэм зорилгод нөлөөлөх боловч үндсэн чиг үүрэгт тусгагдаагүй “Ёс зүйн, сахилга хариуцлага, Жендэрийн эрх тэгш, ялгаатай байдал”-ыг хангах чиглэлээр ДГБ-ын бодлогын баримт бичиг, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан. ГЗДАС-д ЭУХ-ийн даргын эрхээр үүрэг даалгавар оруулж, Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн даргын хамт хэрэгжилтийг дүгнэн ажилласан. | | |
| **8** | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | Ажлын цаг ашиглалтыг тухай бүр нүүр таних програмд бүртгүүлж, ажлын шаардлагаар илүү цагаар ажилласан цагийг гүйцэтгэлээр баталгаажуулсан байна. | Хэрэгжилт: “Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Сангийн Сайдын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 06 дугаар тушаалаар ГЕГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтэс нь батлагдсан.<br>ГЕГ-ын ЗББНДБ, орон тоог ГЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан. Тус хэлтэс нь дарга, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч зургаа, нийт найман хүний бүрэлдэхүүнтэй батлагдсан.<br>2024 онд 7 хүний орон тоотойгоор хэлтсийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан. Ажиллах хугацаандаа албан хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт тавьж, тухай бүр нүүр таних программд бүртгүүлж, ажлын шаардлагаар илүү цагаар ажилласан цагийг гүйцэтгэлээр баталгаажуулж, ЗУГ-т хянуулж ажиллав.<br>- Тайлант хугацаанд тус хэлтэст ажиллавал зохих 8 албан хаагчаас нэг орон тоо дутуу ажилласан. Нийт 7 албан хаагчдын ажиллавал зохих 14,344 хүн өдрөөс ажиллахаас 14,147 хүн/өдөр, ГЕГ-ын тушаалаар цалинтай чөлөөтэй 2 хүн буюу 24 хүн/өдөр байна.<br>- Ажлын шаардлагаар түр хугацаагаар болон бусад нэгжид шилжсэн албан хаагч болон ГЕГ-ын даргын тушаалаар чөлөө авсаныг хасвал ажлын цаг ашиглалт 98.6 хувьтай ажилласан.<br>- Ажлын шаардлагаар 2024 оны 01 дүгээр сарын 19-ны 02/265 дугаар албан бичгээр Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч Т.Тэмүүлэн, Улс хоорондын шуудан илгээмж дэх гаалийн газрын гаалийн улсын байцаагч Н.Мөнхсайхан, М.Долгион, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч Б.Дэлгэрмаа нарийг тус хэлтэст түр хугацаагаар ажиллуулсан.<br>- Харьяа гаалийн газар, хороодоос эрсдэлийн удирдлага хариуцсан гаалийн улсын байцаагч томилогдсонтой холбоотой тус хэлтэст дадлагажуулж сургасан. | 2024.01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Тус хэлтсийн гаалийн улсын байцаагч Ж.Жаргал-Эрдэнэ нь ГЕГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Б/410 дугаар тушаалаар Сургалтын төвд багш гаалийн улсын байцаагчаар 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн сэлгэн ажилласан. ГЕГ-ын даргын 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн Б/657 тушаалаар гаалийн улсын байцаагч Т.Тэмүүлэн урт хугацааны сургалтын чөлөө авсан. ГЕГ-ын тушаалаар 2024 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс гаалийн улсын байцаагч Н.Энхтайван ЭУХ-т шилжүүлэн ажилласан.<br>- Цаашид тус хэлтэст албан хаагчийн хэрэгцээ шаардлага үүсэж байгаа тул Хүний нөөцийн хэлтэст 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн №2024/111 тоот дотоод зурвасаар хүсэлт хүргүүлсэн.<br>- Орон тооны дутуу байдал болон үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн ажлын улмаас 136 хүн/өдөр ажилласан байна. | | |

## Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 8 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан байдлыг тайлагнасан байна. | Гаалийн газар, хороодод зөвлөмж өгч ажилласан.<br>1. “Гаалийн байгууллага 2024 онд” танилцуулга<br>- ДГБ-ын 2024 оны уриа, ГЕГ-ын 2024 оны зорилттой уялдуулан гадаад худалдааг хөнгөвчлөх, эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтыг зохион байгуулах, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрхэн ажиллах чиглэлийг харьяа гаалийн газар, хороодод цахим хэлбэрээр өгсөн.<br>2. Гаалийн газар, хороодын орчны судалгаа<br>- “Гадаад худалдааны орчны судалгаа 2018-2022”-ыг хийсэн загварын дагуу тухайн гаалийн газар, хорооны хяналтын объектыг харуулсан 2021-2023 оны судалгааг хийж, эрсдэлт орчноо тодорхойлоход дэмжлэг үзүүлсэн.<br>3. Шалгалтын үр дүнгийн санал<br>- Шалгалтын үр дүнгийн саналд хэрхэн дүн шинжилгээ хийх зөвлөмжийг ГУБ нар хариуцсан гаалийн газар, хороодод тухай бүр өгч ажилласан.<br>4. Мэдүүлэг буцаалт, гаалийн хяналтын төлөв өөрчлөлтөд хэрхэн дүн шинжилгээ хийх тухай<br>- Өдөр бүр, долоо хоног, сар, өссөн дүнгээр гаалийн хяналтын төлөвийн судалгааг хэрхэн хийх форматыг гарган харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлага хариуцсан ГУБ нарт хүргүүлж, системийн хэмжээнд нэг загвараар гаалийн хяналтын төлөвийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн.<br>- Эрсдэлийн удирдлага хариуцсан ГУБ нар мэдүүлэг засварт буцаалтад дүн шинжилгээ хийж, бичиг баримтын болон хяналт хариуцсан ГУБ нарт зөвлөмж, чиглэл өгч ажилласнаар мэдүүлэг засварт буцаах эрсдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7 хувиар буурсан.<br>5. Эрсдэлийн тооцох арга зүйгээр хангасан<br>- “Эрсдэлийн удирдлагын хэлтсийн чиг үүргийн хэрэгжилтийг хангахтай холбоотой эрсдэлийн судалгаа”-г ГЕГ-ын ЗББНДБ-д нарт цахимаар өгсөн. Нэгжийн эрсдэл тооцоход дэмжлэг болох арга зүйгээр хангасан.<br>6. “Risk management 2023-2024” групп нээж, харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлага хариуцсан албаны дарга, ГУАБ, ГУБ нарыг шуурхай мэдээллээр хангах<br>- ГЕГ-ын ЭУХ, харьяа гаалийн газар, хороодын чиглэл хариуцсан албан хаагчид судалгаа, дүн шинжилгээ хийх, гаалийн хяналтын төлөвт дүн шинжилгээ хийх, аж ахуйн нэгж, иргэдийн хууль сахилтыг тодорхойлох болон худалдааг хөнгөвчлөх чиглэлээр оны эхнээс 63 зураг, хүснэгт, ворд файл солилцож ажилласан. | 2024.01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Үүний үр дүнд гаалийн газар, хороодын шалгалтын үр дүнгийн санал бичих чанар, мэдүүлэг буцаалт, шалтгаангүй төлөв өөрчлөх эрсдэл буурсан.<br>- Тайлант хугацаа (2024.06.10)-нд хяналтын “ногоон”, “улбар шар” төлөвийн нийт 36 мэдүүлгийг “Улаан” төлөвд өөрчилсөн байна. Үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад (2023.06.10: “ногоон”, “улбар шар” төлөвийн нийт 213 мэдүүлгийн төлөвийг өөрчилсөн) төлөв өөрчлөлт 6 дахин буурсан үзүүлэлттэй байна.<br>7. Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлттэй холбоотой зөвлөмж, чиглэлээр хангах<br>- ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлтийг хүлээн авч, зөвлөмж, чиглэл өгөхийн зэрэгцээ мэдээллийг боловсруулж, Эрсдэлийн удирдлагын программд оруулсан.<br>8. Эрсдэл тооцох арга зүй<br>- Байгууллагын эрсдэл тооцох арга зүйн зөвлөмжийг боловсруулж, 7 нэгжтэй биечлэн хоёр талт уулзалт зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөмж өгсөн.<br>- Гаалийн байгууллагын “Хууль сахиулах, Төсвийн орлого бүрдүүлэх, Худалдааг хөнгөвчлөх, Чадавхыг бэхжүүлэх” чиг үүргийн хүрээнд эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтыг зохион байгуулахад учирч болзошгүй эрсдэлийг “Хууль тогтоомж; Захиргаа/институци; Хүний нөөц, сургалт болон санхүү; Технологийн дэмжлэг; Харилцаа холбоо, мэдээлэл солилцоо” гэсэн таван хүчин зүйлийн хүрээнд тооцон, тэргүүлэх чиглэлийг гаргаж, байгууллагын хэмжээнд “Эрсдэлийг бууруулах арга хэмжээ”-ний саналыг ГЕГ-ын дарга, дэд дарга, Гаалийн байгууллагын 2025-2028 оны Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>9. Эрсдэлийн удирдлагын чиглэлээр албан хаагчдыг мэргэшүүлэх<br>- СЭГГ, БӨГГ, УХШИГГ, ЧХОУНБГГ-ын эрсдэлийн удирдлага хариуцсан байцаагч нарыг ГЕГ-т богино хугацаагаар ажиллуулж, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшүүлсэн.<br>- ГУБ-ийн анхан шатны 2 сургалтад “Эрсдэлийн удирдлага, ИААН” чиглэлээр 16 цагийн хичээл орж, 75 шинэ албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>Цаг үеийн шинжтэй “Ажлын хэсэг”-т орж ажилласан:<br>- ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг (2023.12.19-ний өдрийн А/348)<br>- НҮБ-ын Худалдаа Хөгжлийн бага хурлын төслийн багтай хамтран өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх, төслийн хүрээнд хүлээгдэж буй үр дүн, үр ашгийг тодорхойлох гаалийн байгууллагын үйл ажиллагаатай уялдуулахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг<br>- Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах ажлын хэсэг<br>- Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны хэмжилт хийх баг<br>- ГЕГ-ын Ёс зүйн дэд хороо<br>- Гааль сэтгүүлийн редакцийн зөвлөл<br>- Төсвийн орлогыг бүрдүүлэхтэй холбоотой гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг (2024.06.06, А/339)<br>- Судалгаа, дүн шинжилгээ хийх, үр дүн тайлагнах баг (2024.06.06, А/339)<br>- Уул уурхайн бус, тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудад чиглэсэн Үндэсний экспортын стратеги боловсруулах ажлын хэсэг<br>- "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл (RIBS)"-ийн хүрээнд "Хилийн зохицуулалттай менежмент" сэдвийн хүрээнд сургалтын жишиг хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг<br>- Горхи Мэлхий хад Зайн сургалтын төв байгуулах төсөл боловсруулах ажлын хэсэг (ГЕГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/616 дугаар тушаал) | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - ГЕГ-ын 2025-2028 оны Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг<br>- ИААН-ийн баталгаажуулалт хийх ажлын хэсэг<br>- Төсвийн орлого бүрдүүлэх ажлын хэсэг<br>Хүрсэн түвшин:<br> Ажлын хэсгийн дийлэнх нь худалдааг хөнгөвчлөхтэй холбоотой тул “Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо”, Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам, Гадаад харилцааны яам, ДГБ, ОУВС, НҮБ-ын ХХБХ, Олон улсын худалдааны төв, Монгол Улсын Гадаад худалдааг хөгжүүлэх төсөлтэй хамтран ажиллаж, 26 уулзалт, форумд оролцож, нийт 157 албан хаагчийг хамруулсан.<br> Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг Монгол Улсын Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024.03.22-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан. Уг хороонд ГЕГ-ын дарга, ЭУХ, ХЦХ-ийн дарга нар багтсан.<br> ГЕГ-ын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсэг анх 2017 онд байгуулагдсан ба ГЕГ-ын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотой ажлын хэсгийг дахин шинэчилж, 2024 онд байгуулсан. ГЕГ-ын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлтэй 114 албан хаагч танилцсан. Батлагдсан төлөвлөгөөтэй 157 албан хаагч танилцаж, өөрийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br> НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн Бага Хурал (ХХБХ)-аас Монгол Улсын гаалийн байгууллагын хил дамнасан худалдаа, түүний дотор цахим худалдаа, цахим дамжуулан өнгөрүүлэх үйл ажиллагааны “Бэлэн байдлын үнэлгээ” хийхэд оролцсон.<br> Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах ажлын хэсгийн “Үйлчилгээний худалдаа, Барааны гарал үүслийн дүрэм, Гаалийн журам ба худалдааг хөнгөвчлөх, Оюуны өмчийн эрх, Цахим худалдааны бүлэг, Хууль эрхзүй болон институцын асуудал, Дижитал худалдаа” бүлэгт орсон. ЭЗХЯ-д эхний шатны хэлэлцээний үр дүнг танилцуулж, хоёр, гурав, дөрөвдүгээр шатны хэлэлцээг амжилттай зохион байгуулж, гаалийн байгууллагаас орсон ажлын хэсгийн гүйцэтгэсэн ажлын мэдээллийг Сангийн яам, ЭЗХЯ-нд албан бичгээр хүргүүлсэн. Монгол-Солонгосын ЭЗТХ байгуулахтай холбоотой товч мэдээлэл болон эхний хэлэлцээнд оролцсон тайланг ГЗДАС-ийн Худалдааг хөнгөвчлөх дэд талбарт байршуулсан (мэдээллийн хандалтын тоо 76).<br> Гаалийн бүрдүүлэлтийн 2023 цаг хугацааны судалгаа хийх ажлыг удирдан зохион байгуулж, Судалгааны үр дүнг ГЕГ-ын дарга, дэд даргад танилцуулж, чиглэл авч, Онлайн хуралдаанд танилцуулсан.<br> “Уул уурхайн бус, тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудад чиглэсэн Үндэсний экспортын стратеги боловсруулах ажлын хэсэг”-т орж, ЭЗХЯ, Олон улсын худалдааны төвтэй хамтран ажиллаж “Худалдааг хөнгөвчлөх стратеги”-ийг боловсруулахад оролцсон. ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодод 10 стратегийн төслийг хүргүүлж, мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангаж эцсийн хувилбарыг боловсруулсан. Түүнчлэн гаалийн байгууллагын эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх салбаруудын судалгаа, цаашдын төлөвлөлтийн талаарх мэдээллийг түгээсэн. Нийт 252 албан хаагч дараах мэдээлэлтэй танилцсан байна. | | |
| | | | | Харьяа гаалийн газар, хороодод чиг үүргийн дагуу чиглэл, зөвлөмж хүргүүлж, удирдлага арга зүйгээр хангаж ажилласан байна. | Хэлтсийн албан хаагчдын ажил үүргийн хуваарийг, хяналтын ачаалал, гадаад худалдааны барааны чиг хандлага, газар зүйн онцлог зэрэгтэй уялдуулан шинэчилсэн. Гаалийн газар, хороодыг дараах чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан.<br>- “Гаалийн байгууллага 2024 онд” танилцуулга;<br>- Гаалийн газар, хороодын орчны судалгаа;<br>- Шалгалтын үр дүнгийн санал;<br>- Мэдүүлэг буцаалт, гаалийн хяналтын төлөв өөрчлөлтөд хэрхэн дүн шинжилгээ хийх тухай;<br>- Эрсдэл тооцох арга зүй; удирдлага”; | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Risk management 2023-2024” групп нээж, харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлага хариуцсан албаны дарга, ГУАБ, ГУБ нарыг шуурхай мэдээллээр хангав.<br>ГЕГ-ын ЭУХ, харьяа гаалийн газар, хороодын чиглэл хариуцсан албан хаагчид судалгаа, дүн шинжилгээ хийх, гаалийн хяналтын төлөвт дүн шинжилгээ хийх, аж ахуйн нэгж, иргэдийн хууль сахилтыг тодорхойлох болон худалдааг хөнгөвчлөх чиглэлээр оны эхнээс 83 зураг, хүснэгт, ворд файл солилцож ажилласан.<br>ХГГ-аас СЭГГ, УХШИГГ, ЧХОУНБГГ-ын эрсдэлийн удирдлага хариуцсан байцаагч нарыг тус хэлтэст богино хугацаагаар ажиллуулж, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшүүлсэн.<br>ГУБ-ийн анхан шатны 2 сургалтад “Эрсдэлийн удирдлага, ИААН” чиглэлээр 16 цагийн хичээл орж, 75 шинэ албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>ДГБ-ын 2024 оны уриа, ГЕГ-ын 2024 оны зорилттой уялдуулан гадаад худалдааг хөнгөвчлөх, эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтыг зохион байгуулах, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрхэн ажиллах чиглэлийг харьяа гаалийн газар, хороодод цахим хэлбэрээр хүргүүлж, мэргэшлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.<br>- Шалгалтын үр дүнгийн саналд хэрхэн дүн шинжилгээ хийх зөвлөмжийг ГУБ нар хариуцсан гаалийн газар, хороодод тухай бүр өгч ажилласны үр дүнд шалгалтын үр дүнг худал, буруу бичих эрсдэл буурсан. Түүнчлэн шалгалтын үр дүнгийн саналыг үнэн зөв бичиж байгаа эсэх шалгуурыг ГУБ нарын ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд оруулах саналыг ЗУГ-т хүргүүлсэн.<br>- Өдөр бүр, долоо хоног, сар, өссөн дүнгээр гаалийн хяналтын төлөвийн судалгааг хэрхэн хийх форматыг гарган харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлага хариуцсан ГУБ нарт хүргүүлж, системийн хэмжээнд нэг загвараар гаалийн хяналтын төлөвийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх боломжийг боломжийг бүрдүүлсэн. | | |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| **Д/д** | **Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ** | **Шалгуур үзүүлэлт** | **Гүйцэтгэлийн түвшин** | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **1** | Гаалийн байгууллагын ёс зүйг бэхжүүлэх чиглэлээр ДГБ-ын бодлого, чиглэлийг судлан, мэргэшлийн мэдлэгээ дээшлүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Төрийн албанаас зохион байгуулсан богино хугацааны цахим сургалт, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтын үеэр ерөнхий мэдлэгтэй болсон. | ДГБ-ын Ёс зүйн цахим сургалтад хамрагдсан байна. | · ГЕГ-ын албан хаагч нараас авсан санал асуулгын үр дүнгээр ГЕГ-ын дэргэдэх “Ёс зүйн дэд хороо”-г долоон хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг ГЕГ-ын даргын 2024.04.24-ний өдрийн А/212 дугаар тушаалаар баталсан.<br>· Гаалийн байгууллагын мэдээллийн customs.gov.mn цахим хуудасны Ил тод байдал хэсэгт Ёс зүйн дэд хороо гэсэн цэсийг шинээр үүсгэн, дэд хорооны албаны үйл ажиллагаанд ашиглах ethic@customs.gov.mn цахим шуудангийн хаягтай болсон.<br>Төрийн албаны зөвлөлөөс өгсөн зөвлөмж, хууль тогтоомжоос харахад Ёс зүйн дэд хороог гаалийн газар, хороодод байгуулах шаардлагатай байна. Иймд нэгдсэн чиглэл авахаар Төрийн албаны зөвлөлд цахим захидал илгээсэн. | 01.01-06.05 | 100 |
| **2** | Жендерийн тэнцвэрт болон олон талт байдлыг хангах чиглэлээр ДГБ-аас хэрэгжүүлж | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Ерөнхий мэдээлэлтэй. | Ази, Номхон далайн бүс нутгийн хүрээнд Жендерийн тэнцвэрт болон олон талт байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж | · “ДГБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн гаалийн дарга нарын 25 дугаар дээд хэмжээний уулзалт”-д оролцсон тайланд “Ази, Номхон далайн бүс нутгийн хүрээнд Жендерийн тэнцвэрт болон олон талт байдлыг хангах” чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг оруулж, ГЗДАС-ийн “Гадаад арга хэмжээ” дэд талбарт байршуулж, гаалийн албан хаагч нарт түгээсэн (Хандалтын тоо 50). | 01.01-06.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | буй бодлого, чиглэлийг судлах | | | буй санаачилгаас суралцаж, ЗДА-ын систем программд холбогдох мэдээллийг нэгтгэн, албан хаагчдад хүргэсэн байна. | · ДГБ-ын Хүйсийн тэнцвэрт болон олон талт байдлын ажлын хэсэгт ГЕГ-ын Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, СТ-ийн багш Ж.Жаргал-Эрдэнэ нар орж ажиллаж байна.<br>· Ажлын хэсгийн 2024.06.05-нд цахим хэлбэрээр явагдсан анхны хурлын үеэр ДГБ-ын Нарийн бичгийн даргын газраас танилцуулсан "Гаалийн байгууллагад Жендэрийн эрх тэгш болон ялгавартай байдал" сэдэвт танилцуулгыг ГЗДАС-ийн "Худалдааг хөнгөвчлөх" дэд талбарт байршуулсан.<br>· ГЕГ-ын "Жендэрийн эрх тэгш болон ялгаатай байдал"-ын үнэлгээг хийж ДГБ-ын ажлын хэсэгт 8 дугаар сард хүргүүлэхтэй уялдуулан<br>Үүнтэй уялдуулан ГЕГ-ын Ёс зүйн дэд хороо, Сургалтын төв, Хүний нөөцийн хэлтэстэй хамтран дээрх үнэлгээг хийхээр төлөвлөж байна. | | |
| **3** | Төрийн албанаас зохион байгуулж буй цахим сургалтад тухай бүр хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Төрийн албанаас зохион байгуулж буй цахим сургалтад тухай бүр хамрагдсан байна. | **Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалт:** Төрийн албаны зөвлөлийн 11 удаагийн цахим сургалтад хамрагдаж, дараах мэдээллийг олж авсан.<br>1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төслийн танилцуулга, хэлэлцүүлэг<br>2. "Дижитал шилжилт: Виртуал орчинд ажиллах" - МУИС-ийн Профессор А.Энхбаяр, VR AR MR<br>3. "Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага" – МУИС-ийн зөвлөх, ЭЗШУ-ны доктор, профессор Л.Оюун<br>4. "Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа"<br>5. "Төрийн албаны үнэт зүйл (эрхэмж), үе хоорондын ялгаатай байдал" - МУИС-ийн ахлах багш, доктор Г.Мягмар<br>6. "Монгол төрийн зүтгэлтний хэв шинж (XX зууны эхэн үе)" - "Чингис хаан" музейн захирал, ШУА-ийн гишүүн, академич, түүхийн шинжлэх ухааны доктор С.Чулуун<br>7. "Төрийн албан хаагч нарт зориулсан эх хэл, бичгийн мэдлэг, чадвар, дадлын номын танилцуулга"<br>8. "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын танилцуулга<br>9. "Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмын үйл ажиллагаа"<br>10. "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа"<br>"Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч зөрчихөөс урьдчилан сэргийлэх нь" | 01.01-06.05 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ.............................. (Д.ЦЭНДСҮРЭН) 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ДАВААГИЙН ЦЭНДСҮРЭНГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Эрсдэлийн удирдлагын хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 63,39 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1 | Гаалийн байгууллагын ёс зүйг бэхжүүлэх чиглэлээр ДГБ-ын бодлого, чиглэлийг судлан, мэргэшлийн мэдлэгээ дээшлүүлэх | | 14,5 |
| 2 | Жендерийн тэнцвэрт болон олон талт байдлыг хангах чиглэлээр ДГБ-аас хэрэгжүүлж буй бодлого, чиглэлийг судлах | | 14,5 |
| 3 | Төрийн албанаас зохион байгуулж буй цахим сургалтад тухай бүр хамрагдах | | 14,5 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 14,5 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1 | Хандлага, ёс зүй | 15 |
| 2 | Удирдан зохион байгуулах | 15 |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 15 |
| 4 | Манлайлах | 15 |
| 5 | Багаар ажиллах | 15 |
| 6 | Харилцаа | 15 |

| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
|---|---|---|
| 7 | Мэргэжлийн ур чадвар | – |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 15 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 63,39 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14,5 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 15 |
| **Нийт оноо=** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 92,9 |

**Үнэлгээ өгсөн:** **Төсвийн шууд захирагч**

Гаалийн ерөнхий газрын дарга ............................ (Р.Отгонжаргал)

2024.12.19 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** **Нэгжийн дарга:**

/Эрсдэлийн удирдлагын

Хэлтсийн даргын албан үүргийг

Түр орлон гүйцэтгэгч/ ............................ (Д.Цэндсүрэн)

2024.XII/20 (огноо)